



УЛС ТӨРИЙН  
БОЛОВСРОЛЫН АКАДЕМИ



Konrad  
Adenauer  
Stiftung

ХБНГУ-ЫН  
КОНРАД-АДЕНАУЭР-САН

# ИРГЭН ТАНЫ ОРОЛЦОО- АРДЧИЛЛЫН БАТАЛГАА



Улаанбаатар хот  
2016 он



УЛС ТӨРИЙН  
БОЛОВСРОЛЫН АКАДЕМИ



ХБНГУ-ЫН  
КОНРАД-АДЕНАУЭР-САН

# ИРГЭН ТАНЫ ОРОЛЦОО – АРДЧИЛЛЫН БАТАЛГАА

Нэмж засварласан 4 дэх хэвлэл

1. БИД АРДЧИЛЛЫГ ЯАГААД СОНГОСОН БЭ? . . . . .	3
2. АРДЧИЛАЛ . . . . .	9
3. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ . . . . .	17
4. ИРГЭДИЙН ОРОЛЦОО . . . . .	22
5. АРДЧИЛСАН СОНГУУЛЬ . . . . .	31
6. НУТГИЙН УДИРДЛАГА . . . . .	42
7. АРДЧИЛЛЫГ АЛДАЖ БОЛДОГ, АЛДАХГҮЙН ТУЛД ЯАХ ЁСТОЙ ВЭ? . . . . .	50

*Улс төрийн Боловсролын Академийн сургалтад зориулан бэлтгэсэн энэхүү ном нь зохиогчийн эрхийн дагуу бүрэн хамгаалагдсан бөгөөд зөвхөн КАС, УТБА-ийн зөвшөөрөлтэйгээр ашиглах болно. Энэ нь олшруулах, микрофильм, электрон системд оруулах, боловсруулах зэрэгт хамаарна.*

Манай хаяг:  
Сөүлийн гудамж -22  
Брау Хаус 2-р давхар  
Шуудангийн салбар-44/ шх-869  
Улаанбаатар – 14250  
Утас:70110110

## НЭГ. БИД АРДЧИЛЛЫГ ЯАГААД СОНГОСОН БЭ?

Монгол Улс 1990-ээд оноос коммунист дарангуйллын дэглэмээс ардчилсан тогтолцоо руу шилжилт хийхийн зэрэгцээ төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн тогтолцоо руу нэгэн зэрэг хос шилжилтийг эхэлсэн билээ.

Улс оронд ардчиллын үнэт зүйлсийг бий болгох, зах зээлийн эдийн засгийн харилцааг бүрдүүлэх, цаашлаад Монгол орны хөгжлийн ирээдүйн дүр төрхийг тогтоох шилжилт нь нийгмийн амьдралын бүхий л хүрээг хамарсан. Энэ нь ардчилсан дэглэмтэй, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, зах зээлийн эдийн засагтай, эрх зүйт төр бүхий улс болж хөгжих сонголтын зам юм.


Бид яагаад энэхүү сонголтыг буюу улс төр, эдийн засгийн хос шилжилтийг хийх болов гэдэг нь гадаад, дотоод олон хүчин зүйлээс болон он удаан жилээр оршин тогтнож байсан хуучин тогтолцооны мөн чанар, зөрчилт байдлаас үүдэлтэй юм. Иймд, шилжилтийн өмнөх Монголын нийгмийн улс төр, эдийн засаг, социал, оюун санааны хүрээний амьдрал ямар байсныг эргэн санацгаая.

### 1. Улс төрийн хүрээний амьдрал ямар байв?

Ганц намд бүхэлдээ захирагдмал, улс төрийн нэг үзэл суртал бүхий төвлөрсөн тогтолцоотой байв. “Ардчилсан төвлөн удирдах ёс”, “Социалист төлөвлөгөө” зэрэг нь коммунист төрийн зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн зарчим болж байжээ.

Өөрийн гадаад, дотоод бодлогыг бие даан тодорхойлон явуулах эрхгүй, “Пролетарийн интернационализм, социалист системийн эв нэгдлийг эрхэмлэх”, “империализмыг эсэргүүцэх” зэрэг бусдын заавраар гадаад бодлогоо явуулж байв.

“Ленин багшийн зааснаар коммунизм руу урагшаа!”



*Монгол орон улс төрийн хувьд далан жил социалист систем, түүний дотор хуучин ЗСБНХУ-ын хатуу хяналт дор оршин тогтнож байлаа.*

*Нийгмийг марксист–ленинист номлолоор хөгжүүлэх гэсэн үзэл санаа ноёрхсоны улмаас Монголын төр, засаг нь ард түмнээсээ тасарч хүний үгээр ажилладаг байв. Иргэд төрд өөрийгөө төлөөлүүлж, эрх ашгаа хамгаалуулах төрийн түшээгээ чөлөөтэй сонгох, эсвэл өөрөө сонгогдох эрхээ эдлэх боломжгүй байв.*

*Хүний салшгүй эрх болох амьд явах, итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, өмч хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах, шударга шүүхээр шүүлгэх зэрэг эрхүүд зөрчигдөж ирсэн түүхтэй.*

*Социалист нийгэм нь коммунизмын бүтээн байгуулалтанд хувь хүнийг захируулан, социалист үзэл суртлын дагуу хувь хүний чөлөөтэй хөгжлийг хяхан боогдуулдаг нийгэм байв. Өрнөдийн соёлыг “ялзарснаар” зарлаж, рок, поп хөгжмийг хориглон, үс толгойгоо хүртэл яаж засахыг заадаг байв. Нам төвтэй төрийн тогтолцоонд коммунист үзэл суртал бүхий нэг нам л улс орныг өөрийн дураар удирдаж иржээ. Хэн ч түүнийг шүүмжлэх эрхгүй, найз хооронд ярьсан яриаг хүртэл тагнаж шийтгээдэг хатуу нийгэм байсан юм.*

*Монгол орон далан жил нэг намд захиргаадуулан хянуулж, хувь хүний эрх, эрх чөлөөгөө хязгаарлуулсан албат бүхий тоталитари дэглэмтэй улс байжээ.*

## **2. Эдийн засгийн хүрээний амьдрал ямар байв?**

Эдийн засаг нь “аж ахуйн социалист тогтолцоо”, “социалист өмч” дээр тогтожирсан. Хувийн өмчийг таягдан хаяж, хүн өөрийн хүслээр үйлдвэрлэн бүтээхийг чанд хориглож, хүн бүр төлөвлөгөөгөөр үйлдвэрлэсэн адилхан шахуу хувцас, гуталтай байлаа. Хувь хүнийг өмч хөрөнгөөс нь салгаж, үндэсний баялагийг төрийн нэрээр төвлөрүүлснээрээ хүн амыг бүхэлд нь бусдын гар харагчдын хуаран болгосон юм. Өмчгүй хүн юу ч хариуцахгүй. Ингэснээр хариуцлагын ойлголт социализмын үед үгүй болсон.

Социализмын эдийн засаг нь нэг л төлөвлөгөөтэй, төрийн гэсэн ганц өмчтэй, албадлагын механизмтай, нийгэмчлэгдсэн объектод эдийн

засаг байсан юм. Үүнийг тодруулбал:

- **Бүх зүйл улсын төвлөрсөн хяналтад байсан.** Нийт эдийн засагт нэрлэсэн үнэ ба цалин тогтмол, дотоод санхүүгийн үйл ажиллагаа идэвхгүй, зөвхөн цалин л бэлэн мөнгөөр хийгдэнэ. Цалингийн түвшин, эрэлт, нийлүүлэлтийг улсаас хүчээр зохицуулж иржээ.
- **Төвлөрсөн төлөвлөгөөт зохицуулалт.** Эдийн засгийн үйл ажиллагаа нь төвлөрсөн төлөвлөгөөнд тулгуурлана. Төлөвлөлт нь эдийн засгийн эрчимтэй бус өсөлтийг урамшуулахад анхаарч, тоон өсөлтөд тулгуурлана.
- **Бүх өмч улсын эзэмшилд байсан.** Хувийн өмчийг хүлээн зөвшөөрдөггүй байсан нь жинхэнэ үр ашгийг үгүйсгэж байв. Дотоодын үйлдвэрлэл бараг байсангүй, бүгд гаднаас хамааралтай, бүтээмж, чанар гэх ойлголтыг харгалзахгүй. “Хүн бүрийн ... нандигнан хайрлаж тахин шүтэж байх зүйл нэгдүгээрт, нийгмийн өмч ...” хэмээн хүн бүрт цээжлүүлж байсан лоозонгийн агуулгаас энэ нь тодорхой харагдана.
- **Үнийн гажуудал.** Чөлөөт үнэ гэсэн ойлголт байхгүй. Бүхий л үйлчилгээний (орон сууц, эрчим хүч, тээвэр, боловсрол, эмнэлэг зэрэг) үнэд зардал ямар ч нөлөөлөл үзүүлдэггүй байжээ.

**Зөвлөлт Холбоот Улсын дэлгүүр. 1980 он.  
“Оймс байхгүй. Гутал байхгүй.”**



*“Социализмын материал техникийн бааз байгуулах”-ыг зорьж байсан төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоотой Монгол орон нь улсын нэртэй “эзэнгүйдсэн” өмчтэй, үрэлгэн, зардал ихтэй, үр ашиг муутай эдийн засагтай байлаа.*

## **Тухайлбал,**

1990 оноос өмнө улсын төсвийн орлогын 1/3-ийг үйлдвэр, аж ахуйн газруудын алдагдлыг нөхөхөд зориулж байжээ.

- Хөрөнгө оруулалт, улсын төсвийн 70 гаруй хувийг гадаадаас зээлээр авдаг.
- Нэг хүн амд ногдох ДНБ-ний хэмжээгээр бусад социалист орнуудаас хамгийн бага /100 хүрэхгүй ам.долл/.
- Хөрөнгө, капитал ашиглалтын ашигт үйлийн коэффициент нэн бага.
- Социалист систем нийгмийн баялгийг хамгийн бага бүрдүүлдэг тул хүн амын амьжиргааны түвшин дорой.
- Гадаадад байршуулсан үндсэн хөрөнгө гэж байсангүй.

## **Эдийн засгийн гадаад хүчин зүйл талаас:**

*Монгол орон Социалист системийн Эдийн засгийн Харилцан туслалцах Зөвлөлийн /ЭЗХТЗ/ гишүүн орнуудын хүрээнд түүхий эдийн хавсарга баазын хэмжээнд л ойлгогдож байлаа.*

Монгол Улсын эдийн засаг гадаад орны шууд хараат байдал, хатуу хяналтанд байв. Тухайлбал, худалдаа эдийн засгийн түншүүд, ЭЗХТЗ-ийн хүрээнд хэрэглэх бараа материалын 40%, тоног төхөөрөмжийн 90 гаруй хувь, шатах тослох материалын 100 хувийг гаднаас авч байсан. Мөн Монгол улс социализмын үед жил бүрийн үндэсний орлогынхоо 1/3-тэй тэнцэх зээл тусламж авч, гадаад худалдааны тэнцэл нь экспортын орлогын 50%-д хүрсэн алдагдалтай байв. Ийнхүү Монголын нийт өр 11,7 тэрбум ам.долларт хүрсэн юм.

*“Ард хормойгоороо урд хормойгоо нөхсөн”, бүх зүйл гадаад талаасаа хамааралтай, гаднаас “тэтгүүлсэн” эдийн засгийн тогтолцоо нь улс орны хөгжлийг доройтуулж, түүний дотор хүн амын хүссэнээрээ ажиллаж амьдрах буюу өөрөө бие дааж сонголт хийх боломжийг боогдуулж, төр гэсэн хүчирхэг аппаратаар дарангуйлан захиргаадаж, хувь хүний эрх, эрх чөлөөг хязгаарлаж, “коммунист үзэл сурталтай”, бэлэнчлэх сэтгэлгээ, идэвх оролцоо муу, хувийн санаачлага багатай иргэд болгон хүмүүжүүлж иржээ.*

## **3. Нийгмийн хүрээний амьдрал ямар байв?**

Монголын нийгмийн бүтцийн харилцаанд гагцхүү анги, ангиудын тэмцлийн үүднээс хандаж байв. Тухайлбал, төрийн байгууллагын нийгмийн үндэс нь зөвхөн “ажилчин анги тэргүүтэй хоршоолсон ард”-ын

холбоо байсан бөгөөд энэ хоёрын үр сад болох “хөдөлмөрийн сэхээтэн”-ийг “гуйвамтгай хэсэг” гэж гоочлон энэ санаагаар хуульчилж өөр анги давхрааг устган халах онолоор явжээ. “Ангийн дайсан” гэх нэр хочийг авсан л бол тэр хүний гэр бүл, үр хүүхэд, хамаатан садан бүгд “дайсан” болж хувирдаг байв. Коммунист нийгмийн энэ балгаар гуч гаруй мянган хүнийг хэлмэгдүүлж, буудан алж, харь нутаг руу цөлж ирсэн түүхтэй.



Хилс хэргээр шүүгдэж буй Эрдэнэ зуугийн лам нар. Шүүх хурлын дараа буудан хороожээ. 1937 он

#### **4. Оюун санааны хүрээний амьдрал ямар байв?**

Оюун санаа, соёлын харилцааг “коммунист үзэл суртал”, “үндэсний хэлбэртэй, социалист агуулгатай соёл”-оор хязгаарлаж, өрнө дорны соёл орж ирэхээс айж эмээн хатуу хянан цагдаж байв.

Дэлхийн сонгодог болон орчин үеийн урлаг, хөгжим, яруу найраг, уран зургийг “ангич” шалгуураар ялгаварласнаар Монголчууд бид дэлхийн соёлоос маш ихээр хоцорсон юм.



Ийнхүү Монгол дахь коммунист туршилт нь дэвшин хөгжих бус өөрөө өөрийгөө мөхөөх шинжтэй болсон тул аажмаар түүнийг халж, ардчилалд шилжих үндэс сууриа дотроосоо бүрдүүлж өгсөн юм.

Коммунист систем оршин тогтнох боломжгүй мухардмал байдалд орж цаашид хүн төрөлхтний нийгмийн жам ёсны хөгжлийн дагуу ардчилсан тогтолцоонд зайлшгүй шилжихээс өөр аргагүй байдалд монголчууд хүрсэн билээ.

Коммунист туршилт эцэс болов.



## ХОЁР. АРДЧИЛАЛ

Ардчилал бол өөрийн оршин тогтнож буй хоёр зууны хугацаанд зөвхөн үзэл санаа биш, харин бодит байдал, өөрөө өөрийгөө хөгжүүлэх, хувьсан өөрчлөгдөх чадвартай гэдгээ нотлон харуулсан нийгмийн зохион байгуулалтын хэлбэр юм.

Ардчилал бол чөлөөт нийгмийн тогтолцоо юм. Энэ нийгэмд хүн чөлөөтэй амьдрах таатай орчин, боломж бүрдсэн байдаг.

Ардчилсан нийгэмд иргэд өөрсдийн эрх, эрх чөлөөг эдлэхийн зэрэгцээ үүрэг хариуцлага хүлээдэг.

Ардчилсан нийгмийн иргэд улс төрд идэвхтэй оролцдог, төр засгийн бодлого, шийдвэрийг шүүн хэлэлцэж, тодорхой асуудлаар зөвшилцөж, бие биэндээ хүлээцтэй, тэвчээртэй хандаж чаддаг.

Ардчилсан нийгэмд төрийн эрх мэдэл хуваарилагдсан байна. Эрх мэдлийг засаглалын салаа мөчрүүдийн хооронд тухайлбал, УИХ болон Засгийн газар болон шүүхийн байгууллагын хооронд хуваарилж, харилцан хяналттай, уялдаа холбоотой, тэнцвэртэй байлгана.

Ардчилсан нийгэмд засгийн газар нь иргэддээ үйлчилж, эрх ашгийг нь хамгаалж, эрхээ эдлэхэд нь тусалдаг. Үүний хариуд иргэд нь төр, засагтаа итгэл үзүүлж, дэмжиж байгаагаа илэрхийлдэг бөгөөд ард түмэн засгийн газарт үйлчилдэггүй юм.

Хүн болгонд өөр өөрийн хэрэгцээ, сонирхол, үзэл бодол байдаг. Тэрхүү хэрэгцээгээ хангах, сонирхлоо хэрэгжүүлэх, үзэл бодлоо чөлөөтэй, хэн нэгнээс айж эмээлгүй илэрхийлэх боломж гагцхүү ардчилсан нийгэмд л байдаг. Төр тухайн иргэний өмнө тулгамдсан асуудлыг шийдэх шаардлагын үүднээс иргэдийн хоорондын харилцаанд оролцох нь хүний эрх, эрх чөлөөг зөрчихөд хүргэж болзошгүй байдаг. Ингэснээр иргэний идэвх санаачлага, асуудлыг шийдэхэд оролцох оролцоог нь боогдуулахад хүргэдэг. Ийм учраас төрийн оролцоо нийгэмд бага байх учиртай юм.



*Монголын нийгэмд хүний эрх, эрх чөлөө, ардчиллын үнэт зүйлс, өрсөлдөөний зарчим болон нийгмийн эн тэргүүний зорилтыг янз бүрээр тайлбарлаж, ойлгодог хандлага бий.*

## **Нээлттэй зарчим гэж юу вэ?**

Ардчилал өөрөө нээлттэй нийгэм юм. Ардчилсан нийгэмд төрийн бүх байгууллага, албан хаагчид, улс төрчид нээлттэй ажиллах зарчмыг баримтлах ёстой. Тэдний үйл ажиллагаа иргэдийн өмнө нээлттэй, тунгалаг байх нь төр, иргэн хоёрын итгэлцэл, хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлдэг. Төрийн үйл ажиллагаа нээлттэй байснаар иргэдийн зүгээс улс төрчид, төрийн албан хаагчдад хяналт тавих, тэдний үйл ажиллагааг сайжруулах, авлига, хээл хахуульд өртөхөөс нь урьдчилан сэргийлэх орчныг бүрдүүлнэ.

Төр засаг нээлттэй байвал нийгэмд элдэв цуу яриа гардаггүй. Төр хаалттай байхын хэрээр элдэв цуурхал газар авч, хүмүүсийн сэтгэл санаа тогтвортой бус болж, ардчилал зэврэх магадлал нэмэгдэнэ. Энэ нь эргээд дарангуйллын харилцааг бий болгодог гашуун туршлага түүхэнд бий.

Ардчилсан биш төр өөрийн үйл ажиллагааг нуун далдлахын тулд нийгмийг хаалттай, хатуу хяналттай, мэдээллийг хорьсон, иргэдийг байнгын айдас хүйдсийн дор байлгахыг зорьдог.

*УИХ-ын гишүүд, төрийн албан хаагчдын нээлттэй, ил тод байдал, иргэдийн зүгээс тэдэнд хяналт тавих боломж хөгжлөө олоогүй байна. Энэ нь төрийн түшээд хээл хахуульд өртөх, энэ хэрээр тэдний үйл ажиллагаа хаалттай, нуугдмал болж хувирахад хүргэнэ.*

## **Шударга байх зарчим гэж юу вэ?**

Ардчилсан нийгэм бүх иргэдэд адил тэнцүү боломж олгодог онцлогтой. Энэ нь хэн нэгнийг илүү харж, эрх дарх олгохгүй гэсэн үг юм. Энэхүү ижил боломжийг яаж ашиглах нь тухайн иргэнээс өөрөөс нь хамаарна. Хэн илүү сэтгэж байна, хэн илүү хөдөлмөрлөж байна, тэр хүн баялгаас илүү хүртэнэ. Хэн сэтгэхгүй, бодохгүй, хөдөлмөрлөхгүй байна, тэр баялгаас бага хүртэнэ.

Гэхдээ төр энэ асуудал дээр зохицуулалт хийх үүрэгтэй. Нийгмийн эмзэг, ядуу хэсэгт төр халамжийн бодлого явуулж, тэдэнд туслах ёстой. Нөгөө талаар, энэ ялгаатай байдлыг татварын бодлогоор зохицуулдаг. Хэн их орлого олно, түүндээ тохирсон их татвар төлнө. Хэн бага орлоготой байна, түүндээ тохирсон бага татвар төлнө.

Шударга ёс нийгмийн бүх хүрээг хамрах ёстой. Ялангуяа, хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой асуудалд, түүнчлэн төр ба иргэний хоорондын харилцаанд шударга ёсыг ягштал баримталж байх ёстой. Жишээ нь, шүүх тодорхой гэмт хэргээс үүдэлтэй шийдвэр гаргахдаа

хохирогч, гэмт хэрэгтэн хоёрын аль нэг талыг барилгүй асуудалд хандаж чадвал энэ нь шударга байх зарчим үйлчилж байна гэсэн үг. Төр нь нийгмийн нэг бүлэгт зориулж илүү ая таатай нөхцөл бүрдүүлэн, бусад бүлгийн эрх ашгийг хөсөрдүүлсэн хууль баталж болохгүй. Ингэвэл шударга ёс алдагдана. Ардчилсан бус нийгэмд нэг удирдагч, эсвэл нэг нам зэрэг цөөн хэдэн хүмүүсийн бодлого, зарчим ноёлж байдаг учир тэдний хүсэлд нийцсэн “шударга ёс” тогтож нийгмийг ялгаварлана.

### **Хууль дээдлэх зарчим гэж юу вэ?**

Ардчилсан бус нийгэмд хуулийг биш, харин засгийн эрхийг барьж байгаа нам, бүлэг хүмүүс, удирдагчийн бодлого, зарчмыг илүүд үздэг. Зөвхөн ардчилсан нийгэмд л хууль дээдлэх зарчим хэрэгжих боломжтой бөгөөд хэн нэгэн хуулиас гадуур, дээгүүр байхыг хүлээн зөвшөөрдөггүй. Улс төрийн ямар нам засгийн эрхэнд байна, ямар хүн ерөнхийлөгч байна, хэн өмчтэй эсвэл өмчгүй байна гэдгээс үл хамааран тухайн улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн бүр хуулийг дээдлэх ёстой. Энэ зарчим Үндсэн хууль болон бусад хуулийг хэн нэгэн өөрөөр тайлбарлах, хуулийн хэм хэмжээг өөртөө тааруулж ашиг хайх ёсгүй гэсэн гол санааг агуулна.

Төр ба иргэний хоорондын харилцаанд энэ зарчим байнга үйлчилж байх шаардлагатай. Төрийн гаргасан шийдвэр иргэдийн хүсэл зориг, эрх ашигт нийцээгүй бол түүнийг өөрчлөх эрхээр хангагдаж, шийдвэрийг үл дэмжиж байгаагаа хуулийн дагуу илэрхийлж болно. Төр, ялангуяа, хууль хэрэгжүүлэгчид болох цагдаа, шүүх, прокурор болон аюулаас хамгаалах зэрэг байгууллага тухайн иргэний эрх, эрх чөлөөтэй холбоотой асуудалд /жишээ нь, байцаах, нэгжих, баривчлах болон эрх чөлөөг нь хязгаарлах г.м/ гагцхүү хуулийн дагуу хандах үүрэгтэй.

*Монгол Улсын зэвсэгт хүчин, цагдаа бусад байгууллагыг зарим улс төрчид “хүчний” байгууллага гэж гажуудуулж нэрлэдэг. Дарангуйлагч нийгэмд ингэж нэрлэдэг бол ардчилсан нийгэмд эдгээр нь “хуулийн” буюу “хүний эрхийг хамгаалагч” байгууллага билээ.*

### **Цөөнхийг хүндэтгэх зарчим гэж юу вэ?**

Цөөнхийн эрх олонхийн хүсэл зоригоос үл хамаарах бөгөөд олонхийн “хүч түрснээр” үгүйсгэгдэх ёсгүй.

Цөөнх гэдэг нь харьцангуй ойлголт юм. Хууль батлахад УИХ-ын 76 гишүүний 39 нь дэмжиж, 37 нь эсрэг саналтай байна гэж бодъё. Олонхийн саналаар шийдвэр гаргах зарчмыг дагавал хууль батлагдана.

Гэтэл 39, 37-ийн хооронд маш бага зөрөө байгаа биз. Нөгөө талаар асуудлыг шийдэхэд цөөнх болж байгаа хэсгийн цаана нийгмийн тодорхой бүлэг, иргэд, сонгогчид байдаг. Иймээс хууль тогтоох, шийдвэр гаргах байгууллагад олонхи болсон улс төрийн хүчин хууль батлахдаа, шийдвэр гаргахдаа цөөнхийн эрх ашиг, сонирхлыг ямагт харгалзах механизмтай байдаг. Олонхи нь удирдан захирч, цөөнхийн эрхийг хуулиар болон хуулийн байгууллагаар дамжуулан хамгаалдаг байх ёстой.

Засгийн эрхийн төлөө тэмцэж байгаа улс төрийн нам өөрийн доторх цөөнхийн үгийг сонсдог, тэдний эрх ашиг, сонирхлыг хүндэтгэдэг, олонхи нь цөөнхдөө дарамт шахалт үзүүлдэггүй байх ёстой. Цөөнхтэй холбоотой уг зарчим засгийн эрх барьж байгаа нам болон сөрөг хүчний эсвэл парламентад суудалгүй үлдсэн намуудын хоорондын харилцаанд ч үйлчилдэг. Олонхи нь цөөнхийн эрх ашгийг хөсөрдүүлэх, тухайлбал, хэвлэл мэдээллийн хэрэгслээр үзэл бодлоо илэрхийлэх боломжийг нь хаан боогдуулах, засгийн газрын буруу бодлого, үйл ажиллагааг шүүмжилсэн хүмүүсийг дарамтлах, ял шийтгэл оноох явдлыг хуулиар хатуу хориглоно. Ийм байдлыг гааруулахгүйн тулд ганц улс төрийн нам бус, мөн иргэдийн санаачлага, эсэргүүцэл болон улс төрийн бусад оролцооноос хамаарна.

Ардчилсан бус нийгэмд цөөнхийн эрх ашиг гэдэг ойлголт байдаггүй. Олонхи гэдэг нэрийн дор цөөн хэсэг хүмүүс харин нийт олон түмнийг хяхан хавчиж, эрхийг нь хөсөрдүүлж байдаг.

### **Зөвшилцлийн зарчим гэж юу вэ?**

Улс төрийн намууд эсвэл нийгмийн бүлгүүдийн хооронд үзэл бодол, байр суурийн ялгаа, зөрчил байгаа нөхцөлд бид зөвшилцлийн талаар ярьдаг. Зөвшилцөнө гэдэг бол аль нэг тал нь өөрийн зарчим, байр сууринаас ухарч, нөгөө талынхаа шийдвэр, хүсэл бодлыг дагана гэсэн үг хараахан биш. Гол нь санал нийлэхгүй, зөрчигдөөд байгаа тухайн асуудлыг шийдвэрлэх ерөнхий хандлага, арга замыг хамтарч олох явдал чухал юм.

Хэрвээ засгийн эрхэнд байгаа нам ба сөрөг хүчин, олонхи ба цөөнх, нийгмийн бүлгүүд хоорондоо зөвшилцөлд хүрч чадахгүй бол төрийн тогтолцоо, магадгүй улмаар нийгэм хямралд орох нөхцөл бүрддэг.

Зөвшилцөлд хүрэхийг хүсч байгаа бол тухайн талууд хүлээцтэй байх ёстой болно. Улс төрийн хүлээцтэй байдал зөрчилтэй, маргаантай байдлаас хохирол багатай, хэн нэгний эрх ашгийг хөсөрдүүлдэггүй давуу талтай. Ардчиллын хөгжил дэвшлийг хойш нь чангаадаг, зөрчилтэй байдлыг даамжруулдаг гол зүйл бол хүлээцгүй байдал юм. Ардчилсан бус нийгэмд олонхи ба цөөнх, олон ургальч үзэл гэж байдаггүй учраас

зөвшилцөх, харилцан буулт хийх шаардлага байдаггүй байна.

*Нийгэмд бүхэлдээ, тэр дундаа улс төрийн намуудын дунд зарчмын чухал асуудлаар зөвшилцөх явдал дутагдаж байна. Жишээ нь: Газрын хэвлийн баялгийг зохистой ашиглах, үр шимийг нь нийгэм-эдийн засгийн хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглүүлэх асуудал урагшгүй л байна.*




### **Төлөөллийн ардчилал гэж юу вэ?**

Ардчилал бол хүний эрх, эрх чөлөө, шударга ёс зэрэг олон үнэт зүйлийг өөртөө багтаасан чөлөөт нийгмийн тогтолцоо юм. Ардчиллын янз бүрийн хэлбэрүүд бий. Иргэд улс орны болон орон нутгийн хувьд ач холбогдолтой шийдвэр гаргахад ямар замаар оролцож байна гэдгээс хамаарч шууд болон төлөөллийн ардчилал гэж ангилдаг.

Иргэд өөрсдийг нь төлөөлсөн байгууллагаар дамжуулан төрийн шийдвэр гаргах үйл явцад оролцож байгаа хэлбэрийг төлөөллийн ардчилал гэдэг. Бидний сонгож авсан өнөөгийн ардчилал бол төлөөллийн ардчилал юм.

Харин иргэд ямар нэг төлөөлөлгүйгээр шууд саналаа гаргах замаар тодорхой асуудлаар шийдвэр гаргаж байвал энэ нь ардчиллын шууд хэлбэр юм. Гэхдээ шууд ардчиллын хэлбэр нь цаг хугацаа, орон зай, хэлэлцэх гэж буй зүйл гэх мэт олон асуудлаас хамаарч хэрэгжинэ. Тухайлбал, “Ургамлын төрөл зүйлийг хамгаалах тухай хууль” гаргахаар болвол бүх иргэд энэ асуудлын нарийн ширийн зүйлийг мэдэхгүй байж болно. Ийм учраас яах аргагүй биднээс сонгогдсон төлөөллийн байгууллага, өөрөөр хэлбэл төлөөллийн ардчилал бидэнд хэрэгтэй юм. Төлөөллийн ардчиллын үед шууд ардчилал тодорхой түвшинд, тухайн засаг захиргааны нэгж харьцангуй цөөн иргэдийг хамарч байгаа нөхцөлд шууд ардчиллын хэлбэрийг хэрэгжүүлэх боломж байдаг. Тухайлбал, тухайн баг, хорооны хэмжээнд тулгамдсан худаг ус, бэлчээр болон газрын асуудлыг шийдэхэд иргэд баг, хорооныхоо иргэдийн нийтийн хуралд шууд оролцож, саналаа өгч болдог. Үүнээс гадна улс орны хувьд чухал ач холбогдолтой, суурь асуудал – Үндсэн хуулийн гол заалтуудтай холбоотой нэмэлт өөрчлөлттэй асуудлыг шийдэхийн тулд бүх нийтийн санал асуулга явуулдаг байна.



### Төлөөллийн ардчилалд иргэд ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?

Иргэдийг төлөөлж, иргэдийн өмнөөс шийдвэр гаргаж буй хүн ямар шийдвэр гаргаж байгаа нь, ямар шийдвэрийн төлөө саналаа өгч байгаа нь иргэдэд хамгийн их хамаатай асуудал юм. Тийм учраас иргэдийн эрх ашиг болон сонирхол, үзэл бодлыг хүндэтгэж, шийдвэр гаргахдаа түүнийг харгалзаж байгаа эсэхийг иргэд мэддэг байх ёстой.

Гэтэл зарим иргэд зөвхөн өөрсдийг нь төлөөлөх хүнийг сонгосноор тэдний улс төрд оролцох оролцоо дууслаа гэж үзэх хандлага байдаг. Ийнхүү зөвхөн сонгуульд оролцож, саналаа өгснөөр нийгэмд гүйцэтгэх үүргээ биелүүллээ гэж боддог нь буруу юм.

Сонгуульд оролцоод зогсохгүй өөрсдийг нь төлөөлж буй байгууллага болон төлөөлөгчид хяналт тавих, үйл ажиллагаа нь зөв зүйтэй явагдаж байвал итгэл өгөх, дэмжлэг үзүүлэх, буруу байвал шаардлага тавих, шүүмжлэх, нөлөө үзүүлэх ёстой. Ингэсэн нөхцөлд л төлөөллийн ардчилал хэрэгжиж, иргэдийн оролцоо бүрэн утгаар илрэх юм.

*Сонгогчийн эрх мэдэл*



Иргэд сонгосон төр, засагтаа хяналт тавихгүй бол төлөөллийн ардчилал

бүрэн утгаараа хэрэгжих боломжгүй. Төр хүний эрхийг зөрчиж иргэдийн эрх ашигт үл нийцсэн шийдвэр гаргаж, иргэдийн өмнө тулгамдсан асуудлыг шийдэхгүй байдлыг гаргуулахгүйн тулд иргэд хяналт тавьж нөлөөллөө хэрэгжүүлэх ёстой юм.

Ардчилсан бус нийгэмд эрх баригчид тухайн дэглэмийг ямар нэгэн аргаар хамгаалах, хадгалахыг чухалд үздэг. Тийм учраас улс төрд иргэдийг дээрээс зохион байгуулж албадан оролцуулдаг ба засгийн газрыг эсэргүүцэх, түүнийг бодлого, үйл ажиллагааг шүүмжлэхийг хатуу хориглодог.

### **Төлөөллийн ардчилалд улс төрийн намууд ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?**

Засгийн эрхийн төлөө өрсөлдөн өөрсдийн үзэл бодол, бодлогоо хэрэгжүүлэх зорилготой иргэдийн нэгдэл бол улс төрийн нам юм. Улс төрийн нам нь нийгмийн бусад байгууллагаас улс орны хөгжлийн талаар өөрийн үзэл баримтлал, мөрийн хөтөлбөртэй, үндэсний хэмжээнд зохион байгуулагдсан, олон түмэнд зөвшөөрөгдсөн улс төрийн лидерүүдтэй зэрэг олон шинж чанараар ялгардаг.

Төлөөллийн ардчилалд улс төрийн намууд нь төр болон иргэдийг хооронд нь холбох үүргийг гүйцэтгэнэ. Иргэд улс төрийн намаар дамжуулан улс орны өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд оролцоно. Харин хэвлэл мэдээллийн хэрэгсэл, иргэдийн үүсгэл санаачлагын байгууллага болон сонирхлын бүлгүүд иргэдийн санаа бодлыг илэрхийлэх, дамжуулах үүрэгтэй.

Улс төрийн болон төрийн тодорхой албан тушаал хаших чадвартай, мэргэшсэн хүмүүсийг урьдчилан шилж сонгох, бэлтгэх үүргийг нам гүйцэтгэнэ. Энэ нь тухайн улс төрийн нам сонгуульд ялсан нөхцөлд өөрийн мөрийн хөтөлбөр, бодлогоо хэрэгжүүлэх бэлэн боловсон хүчинтэй болж байна гэсэн үг.

Улс төрийн намууд нийгэм-эдийн засгийн цогц асуудлыг шийдэх, нийгэмд байгаа янз бүрийн сонирхол, эрх ашгийг нэгтгэсэн улс төрийн бичиг баримт болох мөрийн хөтөлбөрийг бэлтгэж, сонгуулийн өмнө сонгогчдод танилцуудаг. Хэрвээ сонгуульд ялж, засгийн эрхэнд гарвал иргэдэд санал болгосон мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх болоцоо тухайн улс төрийн намд бий болно.

Иргэд сонгуульд оролцож аль нэг улс төрийн намын мөрийн хөтөлбөрийг сонгож саналаа өгөхөд тэдэнд улс төрийн мэдлэг, боловсрол зайлшгүй хэрэгтэй. Иргэдэд улс төрийн мэдлэг боловсрол түгээх, түүнийг нь дээшлүүлэх улмаар иргэдийн улс төрийн идэвх санаачлагыг дэмжих, хөгжүүлэх нь улс төрийн намын үүрэг юм.



Ардчилсан бус нийгэмд нэг л нам дангаараа засгийн эрхийг барьдаг учир улс төрийн нам, төр хоёрыг зааглан ялгах боломжгүй байдаг. Иймд дээр дурьдсан нийгмийн үүргүүдийг хэрэгжүүлэх шаардлага байхгүй ба иргэдээ мэдээллээс хол байлгахыг зорино.

## **Төлөөллийн ардчилалд хэвлэл мэдээллийн хэрэгсэл ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?**

Төлөөллийн ардчиллын нэг онцлог бол засаглалын үйлчлэлийн салаа мөчрүүдэд эрх мэдлийг хуваарилдаг явдал юм. Энэ нь эрх мэдлийн нэг дэх салаа мөчир – УИХ нь хууль тогтоож, хоёр дахь салаа мөчир – Засгийн газар нь баталсан хуулийг хэрэгжүүлж, гуравдахь салаа мөчир - Шүүх нь хуулийн хэрэгжилтэд хяналт тавина гэсэн үг. Мөн эрх мэдлийн салаа мөчрүүд нь хоорондоо харилцан уялдаатай, тэнцвэртэй, харилцан хяналттай байх ёстой. Эрх мэдлийг ингэж хуваарилснаар нэг хүнд эсвэл хэсэг бүлэг хүмүүст бүх эрх мэдэл хэт төвлөрөх, ардчилсан бус дэглэм тогтохоос сэрэмжилж байгаа юм.

Харин нийгмийн зүгээс төр засагт хяналт тавих томоохон боломж, суваг бол хэвлэл мэдээлэл юм. Тийм учраас хэвлэл мэдээллийн хэрэгслийг “дөрөв дэх” засаглал хэмээн нэрлэдэг. Хэвлэл мэдээлэл ямар нэгэн байдлаар, өөрөөр хэлбэл хөрөнгө мөнгөний хувьд төр, засгаас болон аль нэг улс төрийн намаас хараат бус, олон нийтийн байсан цагт сая хяналт тавих боломж бүрддэг. Тухайн хэвлэл мэдээллийн байгууллагын удирдлага нь засгийн газраас томилогддоггүй, хараат бус бие даасан байр суурьтай, иргэдэд үйлчилдэг, төр, засагт хяналт тавих зорилготой байсан тохиолдолд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тооцогддог.

Ардчилсан нийгэмд иргэд мэдээлэл олж авах, түүнийгээ ашиглах эрхтэй. Харин мэдээлэл олж авах эх сурвалж нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл болдог. Тэгэхээр хэвлэл мэдээлэл нь нэг талаас иргэдийн сонирхсон янз бүрийн мэдээллийг түгээн цацах үүргийг хэрэгжүүлдэг. Нөгөө талаас, засгийн газрын гаргасан шийдвэрийг иргэд дэмжиж байгаа эсэх, парламентын баталсан хууль иргэдийн эрх ашигт нийцэж байгаа эсэх мөн иргэд төр, засгаас юуг хүсэж, шаардаж байгааг илрүүлэх буюу энэхүү хоёр этгээдийн хооронд зуучлах үүргийг гүйцэтгэдэг.



## ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Үндсэн хууль бол иргэн таны жам ёсны, үндсэн эрхийг баталгаажуулсан гол баримт бичиг мөн. Ингэхдээ хүний эрх, эрх чөлөөг ардчилсан нийгэм, эрх зүйт төрийн мөн чанарт нийцүүлэн тодорхойлсон юм.

Үндсэн хууль бол тухайн нийгмийн зорьж буй гол зорилтыг тодорхойлсон баримт бичиг болно. Монгол Улсын Үндсэн хууль нь эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг монголын ард түмний эрхэм зорилго болгон тунхагласан.

Үндсэн хууль бол төр, иргэн хоёрын хоорондын харилцааны хэм хэмжээг тодорхойлсон гол хууль мөн.

Үндсэн хууль бол иргэн таны эрх чөлөөт амьдралын баталгаа мөн.



### Үндсэн хуулийн харьцуулалт: 1924, 1940, 1960 ба 1992 оны Үндсэн хууль

Монгол Улсын шинэ Үндсэн хууль нь өмнөх Үндсэн хуулиудтай харьцуулахад зарчмын суурь ялгаатай. Социалист тогтолцооны үеийн Үндсэн хуулиуд нь пролетари ангийн байр суурь, нийгэм эдийн засгийн формацийн тухай коммунист онолын үүднээс боловсруулагдаж ирсэн бол шинэ Үндсэн хууль нь нийт хүн төрөлхтний үнэт зүйлийг дээдлэхийн хамт түүхийн шалгуурыг туулж ирсэн либерал ардчилсан үзэл баримтлалд тулгуурласан юм.

**Социалист тогтолцооны  
үеийн Үндсэн хуулиуд,  
/1924, 1940, 1960/**

Бүхнийг мэдэгч төр, гүйцэтгэгч иргэн  
Иргэний эрх, үүргийн нэгдэл  
Төрийн шинж нь: нэг намын удирдлаган дор байгуулагдсан авторитар засаглалтай бүгд найрамдах улс  
Төвлөрсөн удирдлаганд тулгуурласан засаг захиргааны бүтэцтэй нэгдмэл улс

**Ардчилсан тогтолцооны үеийн  
Үндсэн хууль  
/1992/**

Иргэн, төр адил тэгш эрхтэй субъектүүд  
Хүний эрх, эрх чөлөөг анх удаа тунхагласан  
Төрийн шинж нь: Олон намын тогтолцоо бүхий парламентын засаглалтай бүгд найрамдах улс  
Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсны зарчим дээр үндэслэн хэрэгжих нэгдмэл улс

**Иргэн ба төрийн харилцаа**

Иргэн нь төрийн харъяат албат Ямар нэгэн хариуцлага байхгүй. Хамт олон, нам, төрд бүгдийг даатгана.  
Төр, хүмүүсийн амьдралыг бүрэн хянана. Гэрлэлт, цуцлалт хүртэл намын сахилгад холбогдож, хүүхэдгүйн татварыг төрөөс иргэдэд ногдуулна.

Чөлөөт иргэн – өмчлөгч  
Аж ахуйн болон улс төрийн хариуцлагаа өөртөө хүлээн авах чадвартай хувь хүн  
Төр нь хууль, дэг журмыг л хангах үүрэгтэй. Ингэснээр иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалахаас бус хувь хүний амьдралд хөндлөнгөөс оролцох эрх байхгүй.

**Хүний эрх**

Бие хүн нь нийгмийн харилцааны нийлбэр цогц тул хувь хүний эрхийн асуудал ач холбогдолгүй.  
Нийт хүн төрөлхтний үнэт зүйлс /хүний эрх, хувийн өмч/-ийг анги, намын эрх ашигт үндэслэгдсэн ёс суртахуунаар орлуулна.

Хүний эрх бол хүмүүсийн үйл амьдралын салшгүй жам ёсны хэм хэмжээ. Иймд хувь хүн бие даасан, эрх чөлөөтэй байна.

Хүний эрх төрийн эрхээс давамгайлах, хувь хүний өөрийн үзэмжээр үйл ажиллагаа явуулах, эсвэл тодорхой баялаг авах нөхцөл, боломжийг төрөөс хангаж өгөх ёстой.

Төрөөс тогтоосон тунгаар иргэнд тодорхой эрх олгоно. Гэхдээ иргэний үүргийг чухалчилна.

Хүний эрхийг төрөөс тогтоож олгох биш, харин хүн төрснөөс эхлэн эрхээ эдлэх нь жам ёсны зүйл, төр түүнийг хамгаалах үүрэгтэй.

1960 болон 1992 оны Үндсэн хуулиудын заалтуудыг харьцуулж үзвэл дэвшүүлж буй эрхэм зорилго, хүний эрх, эрх чөлөө, төрийн мөн чанар, өмчийн харилцаагаараа өөр хоорондоо үндсээрээ ялгаатай болох нь тодорхой юм.

### 1960 оны Үндсэн хууль

### 1992 оны Үндсэн хууль

“БНМАУ-ын зорилго бол социализмыг төгөлдөр байгуулж цаашдаа коммунист нийгэм байгуулах явдал мөн.”

“БНМАУ бол ардын ардчилсан төрийн хэлбэрээр тогтнон хөгжиж байгаа социалист улс мөн.”

“БНМАУ-ын төр, нийгмийг удирдан чиглүүлэгч хүч бол бүхнийг ялагч марксист-ленинист онолыг үйл ажиллагаандаа удирдлага болгодог МАХН мөн.”

“БНМАУ-ын эдийн засгийн үндэс бол ... үйлдвэрлэлийн хэрэгслийг хувьдаа өмчлөх журмыг халж, хүн хүнээ мөлжих ёсыг устгасны үрээр тогтсон ... үйлдвэрлэлийн хэрэгслийг нийтээрээ өмчлөх социалист өмч мөн.”

“Иргэний ... орлого, хадгаламж, орон сууц, амины туслах аж ахуй, амины хэрэгцээт зүйлс, гэрийн эд хогшлыг аминдаа өмчлөх эрх, түүнчлэн амины өмчийг өвлөх эрхийг хуулиар хамгаална.”

“... иргэд үг хэлэх, хэвлэн нийтлэх, хурал цуглаан хийх жагсаал ёслол үйлдэх эрх чөлөөг хуулиар батлаж олгосон болно.”

“... иргэд шүтэх, бишрэх, шашны эсрэг суртал нэвтрүүлэг хийх эрх чөлөөтэй.”

“... иргэд үйлдвэрчний эвлэл, хоршоолол, залуучууд, биеийн тамирын эвлэл зэрэг байгууллага, соёл шинжлэх ухаан, техникийн нийгэмлэг ... зэрэг олон нийтийн байгууллагад эвлэлдэн нэгдэх эрхтэй.”

“Хувийн ба нийгмийн ашгийг зөв зохицуулах улс нийгмийн эрх ашгийг хувийнхаасаа илүүд үзэж байх.”

“... ардчилсан байгууллыг бэхжүүлэх үйлсэд идэвхтэй оролцож, улсын нууцыг чанд хадгалах, дайснаас ямагт сэрэмжилж байх.”

“Эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно.”

“Монгол Улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, Бүгд найрамдах улс мөн.”

“Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.”

“Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна.” “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.”

“Монгол Улсын иргэн хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй.”

“Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөтэй.”

“Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй.”

“Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй.”

“Хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх.”

“Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн.”

## Хүний эрх, эрх чөлөө гэж юу вэ?

1992 онд шинэ Үндсэн хууль батлагдснаар Монгол Улсад хүний эрх, эрх чөлөө анх удаа бүрэн баталгаажин ардчилсан нийгмийг цогцлон байгуулах суурь үндсүүдийн эхлэл тавигдсан билээ. Иргэн хүн төрийн харъяат албат байж түүний “эрэг, шураг” төдийхөн болж байсан коммунист үзэл баримтлалыг халж амьдралын жам ёсны эрхээ эдлэн төрийн эрх мэдлийг хамтаараа барих бүрэн эрхт, чөлөөт Иргэнийг тунхагласан юм.

Шинэ Үндсэн хуулийн үргэлжлэл болсон салбар хууль, бусад хууль тогтоомж хүний эрх, эрх чөлөөний үзэл санааг тусган хэрэгжүүлсээр байгаа билээ. Хүний эрх, эрх чөлөө нь хүний амьдралаас салгаж болшгүй, аливаа төр, шашин, засаглалын ямар нэг тогтолцооноос олгогддог буюу зөвшөөрөгддөг бус, заяагдмал шинжтэй байдаг.

Хүний эрх, эрх чөлөөг дотор нь иргэний /хувийн/ болон улс төр, эдийн засаг, нийгэм-соёлын, хөгжих эрх, эрх чөлөө гэж ангилан үздэг. Иргэний буюу хүний хувийн эрхэд амьд явах, уучлал хүсэх, халдашгүй чөлөөтэй байх, гэр бүл, захидал харилцааны нууц, эд хөрөнгө халдашгүй байх, өөрийгөө өмгөөлөх, эрх зүйн туслалцаа авах, чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох, шашин шүтэх, эс шүтэх зэрэг эрх багтдаг бол улс төрийн эрхэд төрийг удирдах хэрэгт оролцох, төрийн байгууллагыг сонгох, сонгогдох, иргэд чөлөөтэй эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, жагсаал цуглаан хийх зэрэг эрх хамаардаг. Эдийн засаг, нийгэм-соёлын эрхэд хувийн өмчтэй байх, аж ахуй эрхлэх, хөдөлмөрлөх, нийгмийн хамгаалал хүртэх, эрүүл мэндээ хамгаалуулах, сурч боловсрох, шинжлэх ухаан, урлагийн бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх зэрэг эрх багтдаг байна. Хөгжих эрх нь дээрх эрхүүдээс илүү өргөн утгатай эрх юм. Энэ нь хөгжих, тайван эрүүл аюулгүй орчинд амьдрах, өөрийгөө тодорхойлох, нийгмийн бүхий л амьдралд идэвхтэй оролцох нөхцлөөр хангуулах үзэл санаагаар илэрхийлэгддэг.

Ардчилсан улс болсноор хүний эрх, эрх чөлөөний асуудалд санаа зоволтгүй боллоо, хуульд тунхагласнаар аяндаа хэрэгжин биелэгдэнэ гэсэн ойлголт байж болохгүй юм.

*Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.  
Монгол Улсын Үндсэн хууль. 19-р зүйл*

Хүний эрх зөрчигдөх явдал амьдрал дээр тохиолддог. Энэ нь нэг талаас, иргэн эрхээ бүрэн ойлгоогүй, түүнийгээ хамгаалах мэдлэг дутмагаас,

нөгөө талаас, эрх бүхий субъект /байгууллага, хувь хүн/-ээс санаатайгаар болон санамсаргүйгээр хүний эрхийг зөрчих үйл гаргадагтай холбоотой. Иргэдийн зөрчигдсөн эрхийг нутгийн захиргааны болон төрийн төв байгууллагууд сэргээх, хамгаалах талаар хангалтгүй ажилласан гэж үзвэл, захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гарган хандаж хэрэг үүсгэн шийдвэрлүүлэх эрх бүх иргэнд нээлттэй бий.


### Эрх зүйт төр гэж юу вэ?

Хуулийн ноёрхол тогтож, хуулийг дээдэлсэн төрийг эрх зүйт төр гэнэ. Эрх зүйт төрийн гол суурь бол хүний эрх, эрх чөлөөг тунхагласан Үндсэн хууль юм. Үндсэн хуулиар нийгмийн харилцааны гол гол зарчим, хэм хэмжээг тодорхойлдог бөгөөд төрийн үйл ажиллагаа үндсэн хуульд тусгагдсан хэм хэмжээгээр зохицуулагдах ёстой байдаг.

Эрх зүйт төрийн зарчим нь нийгэмд үйлчилж буй бүх эрх зүйн актууд Үндсэн хуульд нийцсэн байхыг шаарддаг.

### Эрх зүйт төрийн дээрх шинжүүдийг авч үзвэл:

- Хууль дээдлэх гэдэг нь төр, иргэн аль аль нь бодлого, үйл ажиллагаандаа хуулийг сахиж, мөрдлөгөө болгохыг хэлнэ.
- Төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл хэмээн хуваарилж, тэнцвэржүүлэн харилцан бие биенийгээ тогтоон барих журмаар ажиллана.
- Хувь хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах нь төрийн зүгээс иргэний нийгмийн хэрэгт үл оролцох зарчмыг баримталж, хүний эрх хэрэгжих нөхцлийг бүрдүүлэх үүрэг хүлээнэ.
- Хуулийг нийгмийн амьдралыг удирдах гол хэрэгсэл болгох орчинг буй болгоно.
- Хувь хүний чөлөөтэй хөгжих үндсэн суурийг бүрэлдүүлэхэд эрх зүйт төрийн агуулга оршино.



## **ДӨРӨВ. ИРГЭДИЙН ОРОЛЦОО**

Иргэдийн оролцоо нь ардчиллын тулгуур үндэс юм. Ардчилсан нийгэмд иргэд төрийн үйл хэрэгт оролцох өргөн эрхээр хангагдсан байдаг.

Иргэдийн оролцоо нь иргэдийн зүгээс улс төрийн системийн бүх түвшинд шийдвэр гаргах үйл явцад нөлөөлөх үйл ажиллагаа юм.

Иргэд төрийн үйл хэрэгт оролцсоноороо эрх баригчдын эрх мэдлийг хязгаарлаж, дур зоргоороо авирлах үйлдлийг таслан зогсооно. Ингэснээр төр, засаг цөөн хэдэн хүнд бус иргэд бид бүхний төлөө үйлчлэх болно.

Иргэд улс төрд оролцохын тулд мэдээллээр хангагдсан байх хэрэгтэй.

Үүнд туслах гол хэрэгсэл нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл юм.

Ардчилсан нийгэмд ч иргэд ганц нэгээрээ улс төрийн шийдвэрт нөлөөлөх боломжгүй байдгаас нийтлэг сонирхлын үндсэн дээр эвлэлдэн нэгддэг.

Улс төрийн нам, сонирхлын бүлэг, иргэдийн үүсгэл санаачлагын хөдөлгөөнд эвлэлдэн нэгдэж, иргэд ашиг сонирхлоо тодорхой шаардлагын хэлбэрээр томъёолон илэрхийлж дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлэхийн төлөө зүтгэдэг.

### **Иргэд ямар замаар улс төрд нөлөөлөх боломжтой вэ?**

Энэхүү асуултанд иргэдийн дийлэнх хэсэг эн түүрүүнд “сонгуульд оролцох замаар” гэж төвөггүй хариулах байх. Сонгууль нь иргэдийн зүгээс улс төрд оролцох хамгийн дөхөмтэй бөгөөд түгээмэл хэлбэр болдог учраас үүнийг бараг хүн бүр мэднэ. Харин иргэдийн зүгээс улс төрийн үйл явцад нөлөөлөх өөр ямар арга зам байдаг тухай Та бодож байсан уу?

Улс төрийг зөвхөн УИХ, Засгийн газар, нам, орон нутгийн удирдлага гэх мэт цөөн тооны л шийдвэр гаргагчдад хамаатай, иргэд биднээс нэлээд хол хөндий зүйл хэмээн ойлгодог нь нийтлэг. Бид нийт нийгмийн чанартай асуудлыг сонгосон төлөөлөгчдөөрөө дамжуулан хууль тогтоох байгууллагын түвшинд шийдэж байгаа.


Харин оршин сууж буй хот, хороо, сум, багийнхаа өдөр тутмын амьдралтай холбоотой олон тулгамдсан асуудлыг анхаардаггүй. Гэтэл бидний эргэн тойронд орчны бохирдол, хог хаягдал, сургууль цэцэрлэг, замын хөдөлгөөн, зөвшөөрөлтэй эсэх нь мэдэгдэхгүй гэнэтхэн эхэлдэг барилгын ажил гэх мэт олон асуудал байсаар байна.



Улс төр хүн бүрт хамаатай юу? Амьдралын олон асуудлын дотроос нийгмийн гишүүдийн цөөнгүй хэсэг нь: 1/ цаашид тэвчихийн аргагүй, 2/ хойшлуулшгүй шийдвэрлэх, 3/ улс төрийн түвшинд хэлэлцэгдэх ёстой гэж тус тус үзвэл тухайн асуудал нь улс төрийн шинжтэй болдог. Аливаа асуудал нийтийг хамарч, зайлшгүй шийдвэрлэгдэх ёстой болвол улс төрийн асуудал болдог. Ийм учраас улс төр бол олныг хамарсан асуудлыг шийдвэрлэх үйл явц юм.

*Иргэдийн улс төрийн үйл явцад оролцох оролцоо бага, тэр хэмжээгээр шийдвэр гаргах, бодлого боловсруулах байгууллага, албан тушаалтнуудад тавих хяналт сул нөхцөлд ардчилал хөгжлөө олохгүй.*






Иргэдийн зүгээс сайн дурын үндсэн дээр бүх шатны төр засгийн шийдвэр гаргах үйл явцад нөлөөлөх үйлдлийг улс төрийн оролцоо гэж ойлгоно.

### Улс төрийн оролцооны хэлбэрүүд:

- А/ Тухайлбал төлөөллийн ардчиллын /сонгууль, нам/ эсвэл шууд ардчиллын шинжтэй /бүх ард түмний санал хураалт, иргэний хөдөлгөөн/ гэж ялгана.
- Б/ Эрх зүйн байдлынх нь хувьд хуулийн хүрээнд /ажил хаялт/ эсвэл хууль бус /хүч хэрэглэсэн хандлага/ гэж ангилна.
- В/ Олон нийт хэр зэрэг хүлээн зөвшөөрдөг эсэхээс нь хамаарч нийцтэй /сонгууль, иргэний хөдөлгөөн/, нийцгүй /өлсгөлөн зарлах/ оролцоо гэж ялгана.

## Улс төрийн оролцооны үндсэн хэлбэрүүд

Орон нутгийн сонгууль	Улсын Их Хурлын сонгууль	Ерөнхийлөгч, УИХ-д хандан өргөдөл, захидал бичих
Бүх ард түмний санал хураалт	Засаг захиргааны байгууллага, албан тушаалтанд хандах	Үндсэн хуулийн Цэцэд хандах
Улс төрийн намд хандах		Хэвлэл мэдээллийн хэрэгсэл
Сонгуульд нэрээ дэвшүүлэх	Хурал, жагсаал, цуглаан	Иргэдийн үүсгэл санаачлагын хөдөлгөөн

Дээрх ангиллаас нэлээд түгээмэл хэрэглэдэг **нийцтэй ба нийцгүй** оролцооны хэлбэрийг тодруулан авч үзье.

Тухайн нийгэмд давамгайлж буй ёс суртахуун, соёлын хэм хэмжээ, үнэт зүйлсэд харшлахгүй оролцоог нийцтэй гэж үзнэ. Тогтсон хэм хэмжээнээс гажсан, нийгмийн дийлэнх хэсгийн үнэлэмжийн баримжаанд тохирохгүй оролцоог нийцгүй гэнэ.

Нийцтэй оролцоонд сонгууль, бүх ард түмний санал асуулга, төрийн байгууллага, албан тушаалтанд хандан захидал бичих, санал хүсэлт тавих, төрийн албан тушаалтантай уулзах уулзалтанд оролцох, ганцаарчлан уулзах зэрэг хэлбэрүүд багтдаг.

Нийцгүй оролцоонд албан байгууллагад хүч түрэн суулт хийх, хууль бус жагсаал цуглаан, ажил хаялтанд оролцох, замын хөдөлгөөнийг хаах, хүн болон эд зүйлийн эсрэг шууд хүчирхийлэл үйлдэх зэрэг орно.

*Надтай, надгүй миний оролцоогүйгээр болох биз гэсэн байр сууринаас аливаад хандсан хэвээр байвал иргэд бидний амьдралд тулгамдсан олон асуудал шийдвэрлэгдэхгүй хуримтлагдан байдал улам хүндрэн хэцүүдсээр байх болно.*

### Улс төрийн оролцоо юунаас эхэлдэг вэ?

Улс төрд ямар нэгэн байдлаар оролцохын тулд улс төрийн үйл явцыг сонирхон ажиглаж, энэ талаар мэдээлэл, мэдлэгтэй байх нь зөв. Асуудлыг

шийдвэрлэх явцад иргэдийн зүгээс өмнөх зурагт үзүүлсэн улс төрийн үйл явцын бүхий л шатанд ялангуяа хэвлэл мэдээллийн хэрэгслийг өргөнөөр ашиглан мэдээлэл авч, өөрийн ойлголт, байр суурьтай болох боломжтой.

### Хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглах арга зам

**Уншигчийн захидал бичих:**

Тухайн мэдээллийн хэрэгслийн гол сэдэв болоод байгаа үйл явдалд зориулж бичих.

**Мэдээ өгөх :**

Юу, Хэзээ, Хаана гэсэн сэтгүүл зүйн үндсэн гурван асуултанд хариулсан, тодорхой байх ёстой.

**Дугуй ширээний ярилцлага** зохион байгуулж сэтгүүлчдийг урих.

**Ил захидал бичих:** олон нийтэд өөрийн үзэл бодол, байр сууриа хүргэх үүднээс бичдэг.

**Хэвлэлийн бага хурал зохион байгуулах:** чухал бөгөөд тулгамдсан асуудлаар мэдээлэл хийхэд ашиглана.

**Нийтлэл бичих:** тодорхой нэгэн асуудлаар байр сууриа товч тодорхой, баримт нотолгоотой, өвөрмөц байдлаар илэрхийлнэ.

**Ярилцлага өгөх:** сэтгүүлчээс ярилцлагын ерөнхий сэдвийг урьдчилан тодруулах, гол санаагаа урьдчилан бэлтгэх, ярилцлагыг түүнрүүгээ чиглүүлэх.

**Цахим сүлжээнд ажиллах:** комент бичих, твитерт жиргэх зэрэг социал ертөнцөд идэвхтэй оролцох.

### Хэвлэл мэдээллийг ашиглахаас үзэл бодлоо илэрхийлэх өөр ямар арга зам байдаг вэ?

Ардчилсан нийгэмд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээлэл авахаас гадна сонирхсон асуудлаараа мэдээлэл эрж хайх, олж авах эрхийг иргэд эдэлдэг.

*Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсын нууцыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах зорилгоор задрүүлж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална.*

*Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйл*

Иргэд бидэнд тодорхой нэгэн асуудлаар өөрсдийн байр сууриа илэрхийлж, шийдвэр гаргагчдад нөлөөлөх өөр нэгэн чухал арга байдаг. Энэ бол захиргааны байгууллага, албан тушаалтанд хандан гаргадаг **өргөдөл, гомдол** юм.

*Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй.*

*Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйл*

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль” 1995 оноос иргэдийн энэхүү эрхийг баталгаажуулан үйлчилж байна. Уг хуулийн дагуу Монгол Улсын иргэн дангаар буюу хамтарч өргөдөл, гомдол гаргах эрхтэй.

- **ӨРГӨДӨЛ** – Төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан хүсэлт. Өргөдөл нь хүсэлт, санал, мэдэгдэл, мэдээлэл, шаардлагын зэрэг шинжтэй байж болно.
- **ГОМДОЛ** – Төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлт юм.

### **Өргөдөл, гомдол гаргахдаа та юу анхаарах вэ?**

1. Өргөдөл гомдлыг бичгээр буюу амаар биечлэн гаргана.
2. Бичгээр гаргасан өргөдөл, гомдолд оршин суугаа газрын буюу шуудангийн хаягаа бичиж, гарын үсгээ зурсан байна.
3. Иргэд хамтран гаргасан өргөдөл гомдолд бүгд гарын үсэг зурж, төлөөлөх эрхээ нотлох баримт бичгийг хавсаргана.
4. Өргөдлийг түүнд дурдсан асуудлыг шууд шийдвэрлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргадаг бол гомдлыг дээд шатных нь байгууллага, албан тушаалтанд гаргана.
5. Төрийн бүх байгууллага өргөдөл, гомдол гаргаагчийг хүлээн авч уулзах байр, өргөдөл гомдол хүлээн авах цагийн хуваарийг тогтоож, нийтэд мэдээлнэ. Хол газраас ирсэн хүнийг хүлээлгэлгүйгээр хүлээн авч уулзана.
6. Өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэнэ.

## Орон нутгийн захиргааны байгууллагад өргөдөл бичих загвар

*Өвөрхангай аймгийн Уянга сумын  
Засаг даргын тамгын газарт  
өргөдөл гаргах нь*

*Халамжийн тэтгэвэрт хамрагдах тухай*

*Иргэн С.Дэнсмаа миний бие олон жил хувиараа мал хариулж нийгмийн даатгалд хамрагдаж чадалгүй тэтгэврийн нас хүрлээ. Би өнчин олон хүүхэдтэй, өөрийн гэсэн мал цөөхөн тул амьжиргааны хувьд хүнд байна.*

*Нийгмийн халамжийн хуулинд нэн ядуу амьжиргааатай, тэтгэврийн нас хүрсэн, нийгмийн даатгалд хамрагдаагүй хүнд халамжийн тэтгэвэр тогтоож олгодог тухай заасан юм байна.*

*Иймд миний амьдралын нөхцөл байдлыг харгалзан зохих журмын дагуу надад халамжийн тэтгэвэр тогтоож өгнө үү.*

*Өргөдөл бичсэн:*

*Уянга сумын 2-р багийн малчин С.Дэнсмаа*

*2016 оны 3-р сарын 20*

### Иргэдийн үүсгэл санаачлагын хөдөлгөөн гэж юу вэ?

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэсэг иргэд эрх ашгаа хамгаалж захиргааны байгууллагын шийдвэрийг хянуулах, эсэргүүцэх, үүссэн асуудлыг шийдвэрлүүлэх үүднээс тэмцэж буй тухай мэдээлэл үе үе гарах болсон билээ. Гол төлөв иргэдийн эрх ашиг шууд хөндөгдөж, тухайлбал амьдардаг орчных нь аюулгүй байдал алдагдах, сөрөг нөлөөлөл гарах зэрэг асуудал тулгарснаас /жишээлбэл хүүхдийн тоглоомын талбай устгах, зөвшөөрөлгүй байшин барилга барих, байгаль орчинд халтай үйл ажиллагаа явуулах, амьдардаг орчных нь ойролцоо нисэх буудал барих г.м./ иргэд ийм алхмыг хийж эхэлдэг нь тодорхой. Эдгээр алхам нь иргэд нийгмийн амьдралд идэвхтэй оролцох эрмэлзэлтэй болсныг гэрчилж байгаа юм.

Амьдралын явцад аяндаа гарч ирдэг, хамрах цаг хугацаа, орон зайн хувьд харьцангуй хязгаарлагдмал, ихэвчлэн иргэдийн эрх ашгийг шууд хөндсөн тодорхой нэгэн асуудлыг иргэд өөрөө өөртөө туслах эсвэл олон нийтийн санаа бодолд нөлөөлж улс төрийн шахалт үзүүлэх “ шууд бус” аргаар шийдвэрлэх үүднээс түр зуур эвсэн нэгдэх нь иргэдийн үүсгэл санаачлагын хөдөлгөөн юм.

## **Иргэдийн үүсгэл санаачлагын хөдөлгөөн ямар онцлогтой вэ?**

- Зорилго нь тодорхой нэг асуудлаар хязгаарлагддаг.
- Иргэдийн хөдөлгөөн нь улс төрийн нам, эвсэл холбоотой харьцуулахад тодорхой хэлбэр, загварт баригддаггүй, илүү хөдөлгөөнтэй, байнга шинээр гарч ирж, устаж үгүй болж байдаг үзэгдэл юм.
- Улс төрийн нам, эвсэл холбоо зэрэг зуучлагч институцийг алгасан, тэднээр дамжуулахгүйгээр шийдвэр гаргадаг, зөвшөөрөл олгодог байгууллагатай шууд харьцан, тэдгээрт ялангуяа хэвлэл мэдээллийн хэрэгслийг өргөнөөр ашиглан шахалт үзүүлдэг.
- Түүнд хэн ч нэгдэж болдог нээлттэй чанар, ямар ч асуудлыг өлгөн авч ажиллах чадвараараа олныг татаж чаддаг.
- Богино хугацаанд өргөн олон дэмжигчтэй болж чаддаг.
- Эгнээнд нь нэгдсэн гишүүдийн идэвхийн түвшингээрээ иргэдийн хөдөлгөөн улс төрийн намтай харьцуулахад хавьгүй өндөр байдаг.

### **Иргэдийн хөдөлгөөн ямар хэлбэрээр явагддаг вэ?**

- Зөөлөн хэлбэр: захидал бичих, өргөдөл гаргах, өргөх бичиг барих, энгэрийн тэмдэг хэрэглэх, өдөрлөг, үдэшлэг хийх, ухуулах хуудас, мэдээллийн самбар, илтгэл, нээлттэй мэтгэлцээн, зурагт хуудас, уралдаан, чимээгүй цуваа, гарын үсэг цуглуулах, маргаантай байгаа асуудлаар мэргэжлийн хүнийг оролцуулсан уулзалт зохион байгуулах, явуулын үзэсгэлэн
- Аядуу хэлбэр: эрдэм шинжилгээний тайлан, сонин хэвлэл, радио телевизэд ярилцлага өгөх, хүндрэл гарсан голомт руу сэтгүүлчдийн аялал зохион байгуулах, тахилга, мөргөлийн аялал хийх, алдар цуутныг татан оролцуулах, шүүхэд хандах, олныг хамарсан эсэргүүцлийн цуглаан хийх, жагсаал, марш, хүн-гинж зохион байгуулах
- Хурц хэлбэр: замын хөдөлгөөнийг хаах, өлсгөлөн зарлах, захиргааны байгууллагын хаалга үүдийг бөглөх, байшин барилга эзлэх


Иргэдийн хөдөлгөөн нь ардчилсан зарчмыг бэхжүүлэх, нийгмийг урагшлуулан хөгжүүлэхэд дараах үүрэгтэй байдаг.

- o Иргэдийн хөдөлгөөн нь улс төрийн нам, сонирхлын бүлгийн анхаарлын гадна үлдсэн асуудлыг тодорхойлон хөндөж чаддаг.
- o Төрийн зүгээс шийдвэрлэхгүй байгаа асуудалд олон нийт болон төрийн анхаарлыг хандуулдаг.

- o Иргэдийн хувьд ардчиллын жинхэнэ сургууль болж, улс төрийн мэдлэг, туршлага олох талбар болдог.
- o Хамтын ажиллагааны давуу тал, хүчийг мэдрүүлснээр нийгэмд хамтач үзэл санаа төлөвшихөд түлхэц үзүүлдэг.

Ардчиллын замаар олон жил хөгжиж буй улс орны иргэдийн хөдөлгөөнд зөөлнөөс эхлээд замын хөдөлгөөнийг хаах хүртэл үйл ажиллагааны хурц ширүүн хэлбэрүүд ашиглагддаг.

### Иргэдийн үүсгэл санаачлагын хөдөлгөөний үе шат

<p>1-р шат Зарим нэгэн иргэн бий болсон байдлыг зохисгүйд тооцно эсвэл хэрэгжүүлэхээр завдаж буй зарим зүйлийг эсэргүүцнэ.</p>	<p>2-р шат Иргэд тухайн асуудлыг олон нийтийн сонорт хүргэх ажлыг хийнэ: сонин хэвлэлд нийтэлнэ, ухуулах хуудас тараана г.м.</p>	<p>3-р шат Захиргаа, ИТХ, намд хандан захидал бичнэ.</p>
<p>7-р шат Боломжийн шийдлүүдийг хянана. Иргэдийн хөдөлгөөн асуудлыг шийдвэрлэгдсэн гэж үзэж тарна эсвэл цаашид үргэлжлүүлэхээр шийднэ.</p>	<p>Бид эсэргүүцэж байна.</p> 	
<p>6-р шат Засаг захиргааны байгууллагууд болон намын бүлэг зөвшилцөнө.</p>	<p>5-р шат Улс төрийн намууд оролцож эхэлнэ: хэвлэлийн мэдээ гаргах, асуулаа тавих.</p>	<p>4-р шат Иргэдийн хөдөлгөөнийг үүсгэн санаачлана /зохион байгуулалтын хэлбэр, сонгууль/, олон нийттэй харилцах ажил, дэмжигчдийн хүрээг өргөжүүлэх, мэргэжлийн хүмүүсийн дэмжлэг авах.</p>

Иргэдийн хөдөлгөөнийг зөвхөн аливаа болохгүй, бүтэхгүй байгаа зүйлийг өлгөн авч гардаг, төртэй сөргөлдсөн ажиллагаа хэмээн өрөөсгөл ойлгож болохгүй.

Төрийн анхаарлын гадна үлдсэн асуудлыг иргэдийн зүгээс анхааруулан, шийдвэрлэх ёстой гэсэн дохио өгч, асуудлыг хамтран хэлэлцэж, шийдвэрлэх талаар иргэн, төр хоёр хамтран ажиллаж, харилцан бие биенээ дэмжих арга хэлбэр хэмээн ойлгох нь зүйтэй. Иргэд нь улс төрийн идэвхтэй байвал төр өөртөө үүрэх ачаанаасаа хөнгөлөх нь төрд ч ашигтай байх учраас иргэний идэвх санаачлагыг дэмжих шаардлагатай байдаг.

## ТАВ. АРДЧИЛСАН СОНГУУЛЬ

*Энэ бол сонгогч та төрийн эзэн байх эрхээ эдэлж буй үйл явц.*

*Энэ бол төрийн эзэн та ирэх дөрвөн жилд улс орныхоо хөгжлийг тодорхойлоход оролцох торгон агшин юм.*

*Энэ бол төрийн эзэн та ирэх дөрвөн жилд өөрийгөө төлөөлөх итгэмжит хүнээ сонгох мөч юм..*

*Энэ бол өөрийг тань төлөөлж, хүсэл бодол ашиг сонирхлыг тань хэрэгжүүлэх төлөөлөгчдөөс бүрдсэн төр засаг тогтоож буй хэрэг мөн.*

*Энэ бол сонгогч таны улс төрийн хүсэл зоригоо илэрхийлэх чухал хэрэгсэл мөн.*

*Энэ бол та төрийн үйл хэргийг удирдахад оролцох, сонгох, сонгогдох эрхээ эдэлж буй хэрэг мөн.*

*Энэ бол ардчилах үйл явцын чухал үзүүлэлт юм. Хэнд төрийн эрх мэдлийг итгэмжлэн шилжүүлэхийг гагцхүү сонгогч олонхийн саналаар шийднэ.*

*Энэ бол итгэл хүлээж чаддаггүй төлөөлөгчтэй,*

*мөн тийм төлөөлөгчдөөс бүрдсэн төртэй хариуцлага тооцох боломжийг танд өгч буй хэрэг мөн.*



### **1990 оноос өмнө бид сонгуульд хэрхэн оролцож байв?**

- *Аль ч шатанд депутатад нэр дэвшигчдийг захирагч ганц намын зүгээс тогтоож бидэнд тулгадаг.*
- *Нэг тойрогт ганцхан МАХН-ын нэг л нэр дэвшигч байв.*
- *Сонгогчдыг албадан толгой дараалуулан сонгуульд оролцуулна.*



Социализмын үеийн саналын хуудас.

Саналын хуудсыг сонгогч 1 нугалж хайрцагт хийнэ.

**Сонгуулийн хуудас**  
БНМАУ-ын АИХ-ын сонгуулийн . . . аймаг дахь . . . р  
тойргийн . . . р хэсэг.  
6/22/89

Нэр дэвшигчийн овог нэр

Гонгорын Баатар

Сонгуулийн хэсгийн дарга . . . . .

Нарийн бичгийн дарга . . . . .

**АИХ-ын сүүлийн 11 удаагийн сонгуулийн дүн**

Сонгууль болсон он, сар, өдөр	Нэр дэвшигчид	Сонгогдсон депутат	Сонгогчдын оролцоо
1951.06.10	195	195	99.42
1954.06.13	295	295	99.89
1957.06.16	233	233	99.97
1960.06.19	267	267	99.98
1963.03.09	270	270	99.98
1966.09.26	287	287	99.99
1969.06.22	297	297	99.98
1973.06.24	336	336	99.99
1977.06.19	354	354	99.99
1981.06.21	370	370	99.99
1986.09.22	370	370	99.99

**Ардчилсан, чөлөөт, шударга сонгууль гэж юуг хэлэх вэ?**

- Олон нам тэдгээрээс нэр дэвшигчид сонгуульд чөлөөтэй оролцож, шударгаар өрсөлдөх адил тэгш бололцоотой.
- Нэг тойрогт олон нэр дэвшигч, улс төрийн нам, эвсэл өрсөлдөнө.
- Иргэд сонгуульд оролцох, саналаа өгөх эсэхээ, хэний төлөө саналаа өгөхөө хэнээр ч заалгалгүй өөрсдөө шийднэ.

## Өнөөдрийн саналын хуудас.

### Саналын хуудас

Монгол Улсын УИХ-ын сонгуулийн . . . р тойргийн . . . хэсэг.

Тайлбар: сонгогч өөрийн сонгох нэр дэвшигчийн өмнөх дугаарыг дугуйлна уу.

2012 оны 06 сарын 28

д/д	Нэр дэвшигчийн овог нэр	Нам эвслийн харьяалал
1	Гонгорын Баатар	МАН
2	Батын Нямаа	Ардчилсан нам
3	Доржийн Цэцгээ	Шударга ёс эвсэл
4	Ядамжавын Дэлгэр	ИЗНН
5	Даржаагийн Тэмүүлэн	Бие даагч

Сонгуулийн хэсгийн дарга . . . . .

Нарийн бичгийн дарга . . . . .

### УИХ-ын 5 удаагийн сонгуулийн дүн /АИХ, УИХ/


Сонгууль болсон он, сар, өдөр	Нэр дэвшигчид	Сонгогдсон гишүүд	Сонгогчдын оролцоо
1990	2413	430	95.10
1992	293	76	95.60
1996	302	76	92.15
2000	602	76	82.43
2004	244	76	81.82
2008	356	76	76.5
2012	354 /190*/	76	65.24

\* - Жагсаалтаар 190 нэр дэвшигч бүртгүүлсэн.

*Ардчилсан сонгуулийн утга учир нь сонгогч хоёр ба түүнээс дээш тооны нэр дэвшигч, улс төрийн нам, эвслээс тогтмол хугацаанд нийтээрээ, чөлөөтэй, шууд, тэгш эрхтэй, нууцаар сонголт хийхэд оршино.*

### Сонгогч та ямар эрхтэй вэ?

1. Сонгогч та өөрийгөө төлөөлөх төрийн түшээг сонгох эрхтэй. Сонгосон төлөөлөгч итгэлийг тань хөсөрдүүлбэл та хариуцлага тооцох эрхтэй.
2. Сонгогч та тогтмол хугацаанд, чөлөөтэй, бүх нийтээрээ сонгуульд оролцох эрхтэй.
3. Сонгогч та аль ч улс төрийн намд элсэх, эсвэл элсэхгүй байж болох эрхтэй.
4. Сонгогч таныг хэлмэгдүүлж болзошгүй тул та нууцаар саналаа өгөх эрхтэй.



5. Сонгогч та сонгохыг хүсэхгүй байгаа хүний төлөө саналаа өг гэсэн хавчлага, дарамтанд өртөхгүй байх эрхтэй.
6. Сонгогч та УИХ, Засгийн газар, Ерөнхийлөгч, Шүүх хэрхэн ажиллаж байгаа тухай мэдэх эрхтэй.
7. Сонгогч та нам, эвсэл, нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөртэй танилцаж, улс төр, эдийн засаг, боловсрол, ажлын туршлага, улс төрийн намын гишүүнчлэлийнх нь тухай мэдэх эрхтэй.
8. Сонгогч та нэр дэвшигчдийн мөнгөний эх үүсвэр, сонгуулийн кампанийг нь хэн санхүүжүүлж, хэр их мөнгө зарцуулж байгааг мэдэх эрхтэй.
9. Сонгогч та сонгосон төрийн төлөөлөгчөө хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгааг хянах эрхтэй. Энэ нь УИХ-ын гишүүд тодорхой асуудлаар саналаа хэрхэн өгч байгааг сонгогч та мэдэх эрхтэй гэсэн үг.
10. Сонгогч та ямар нэгэн хууль, төрийн бодлогын талаар төлөөлөгчидтэйгээ биечлэн уулзах, захидлаар харилцах, утсаар ярих зэрэг хэлбэрээр санал бодлоо илэрхийлэх эрхтэй.

### **Бид яагаад сонгуульд идэвхтэй оролцох ёстой вэ?**

Сонгуулийн эцсийн зорилго нь та бүхний хүсэл зоригийг илэрхийлэгч, та бүхний дуу хоолой болсон төлөөлөх байгууллагыг л сонгоход чиглэгдэх учраас энэхүү үйл ажиллагаанд өөрийн байр суурьгүй, идэвхгүй оролцвол эргээд таны ашиг сонирхол, хүсэл эрмэлзлэл талаар болно гэсэн үг.



Яагаад гэвэл өөрсдийнхөө төлөө үйлчлэх, өөрсдийгөө төлөөлөх байгууллагаа өөрсдийн л идэвх оролцоотойгоор байгуулсан тохиолдолд тэрхүү төр засгаас гарч буй бидний амьдралд хамаатай бүхий л шийдвэрүүд бид бүхний төлөө байх болно.

Биднийг төлөөлж, “та бүхний хүсэл бодол, итгэл хүсэлтийг хэрэгжүүлнэ” гэж сонгогдон гарч ирсэн тэдгээр төлөөлөгчдийг хянах, хариуцлага тооцох боломж олгохын тулд манай оронд сонгуулийг тогтмол хугацаанд дахин явуулдаг. Биднийг бүрэн төлөөлж чадахгүй байна гэсэн төлөөлөгчдөд дахин итгэл өгөхгүй байх эрхээ бид дөрвөн жилийн дараа явагддаг ээлжит сонгуулиар эдэлдэг. Энэ нь сонгогч та бүхэнд Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон **“Монгол Улсад засгийн эрх ард түмний гарт байна. Монголын ард түмэн төрийн хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ”** гэсэн заалт хэрэгжиж буй хэрэг мөн.

Ардчилсан сонгууль дараах үндсэн зарчмуудыг баримтална. Үүнд:

1. Бүх нийтийн зарчим
2. Чөлөөтэй сонгох
3. Шууд сонгох
4. Саналаа нууцаар гаргах
5. Тэгш эрхийн зарчим

- Бүх нийтийн зарчим нь тухайн улсын сонгуулийн насанд хүрсэн, эрх бүхий нийт иргэд сонгуульд оролцож саналаа илэрхийлэх боломж юм.

*Санал авах өдөр эх орондоо байгаа, Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэн үндэс, угсаа, хэл, арьсны өнгөө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол ялгаварлахгүйгээр сонгох эрхтэй. Гагцхүү эмнэлгийн дүгнэлт, шүүхийн шийдвэрээр ухаан солиотой нь нотлогдсон, түүнчлэн хорих газар ял эдэлж байгаа хүн сонгуульд оролцохгүй.*

*Монгол Улсын Сонгуулийн тухай хуулийн 4, 11 дүгээр зүйл*

- **Чөлөөтэй сонгох зарчим** гэдэг нь сонгуульд оролцох, эс оролцох, хэний ч дарамт шахалтад оролгүйгээр саналаа чөлөөтэй илэрхийлэх, сонгуулийн үйл явц, сонголт хийх боломж нь өргөн байхыг хэлнэ. Санал бол эрх мэдэл юм. Ийм учраас сонгуульд оролцож саналаа өгдөггүй хувь хүн, бүлгийн эрх ашиг хохирч болзошгүй байдаг. Заримдаа сонгуулийн үр дүн ганцхан саналаас хамаардаг. Тэр санал сонгуульд оролцоогүй таны санал ч байж мэдэх учраас сонгуульд идэвхтэй оролцон ухаалаг сонголт хийх нь хамгийн зөв шийдэл болно.
- **Шууд сонгох зарчим** нь нийт иргэдийн санал хураалтаар сонгуулийн эцсийн дүн тодорхойлогдохыг хэлнэ.

Монгол Улсын иргэн УИХ, Ерөнхийлөгч, ИТХ-ыг ямар нэгэн төлөөлөлгүйгээр өөрөө очиж саналаа өгнө гэсэн үг. Энэ нь сонгогчид нэр дэвшсэн хүн, нам, эвслийн аль алины төлөө саналаа өгч болохыг илтгэнэ. Гагцхүү энэ саналын эцсийн үр дүнгээр УИХ, ИТХ бүрдэж, Ерөнхийлөгч сонгогдсон байх ёстой.

*Сонгууль шууд байна. Сонгуульд сонгогч ямар нэгэн төлөөлөлгүйгээр оролцон саналаа өөрөө гаргана.*

*Монгол Улсын Сонгуулийн тухай хуулийн 4.1-4.5 дугаар зүйл.*

- **Саналаа нууцаар гаргах зарчим** нь сонгогч хэний ч нөлөөнд автахгүй зөвхөн өөрийн ухамсартай үйл ажиллагаагаар бие дааж саналаа илэрхийлэх боломж юм. Таны гаргасан саналыг хэн ч мэдэх ёсгүй. Иймээс иргэн танд хэлмэгдэнэ гэж айлтгүй, хэний ч нөлөөнд авталгүй саналаа чөлөөтэй гаргах нөхцлийг хуулиар олгосон юм.

*Сонгогч саналаа нууцаар гаргана. Сонгогчоос саналаа чөлөөтэй илэрхийлэхэд саад учруулахыг хориглоно.*

*Монгол Улсын Сонгуулийн тухай хуулийн 4.5 дугаар зүйл.*

- Тэгш эрхийн зарчим нь нэг сонгогч нэг л удаа саналаа гаргах, сонгогчид

адил саналын эрхтэй байх, сонгогч бүрийн саналын хувийн жин ижил байх, нэг тойрог дахь сонгогчдын тоо тэгш байх нөхцлийг хэлнэ.

### **Сонгуулийн зохион байгуулалт**

Сонгуулийн үйл явцыг амжилттай сайн удирдан зохион байгуулж, чөлөөт, шударга сонгууль явуулахад сонгуулийн хороодын гүйцэтгэх үүрэг шийдвэрлэх ач холбогдолтой байдаг.



Ийм учраас сонгогчид, хэвлэл мэдээллийнхэн, ажиглагчид, улс төрийн намууд сонгуулийн хорооны зүгээс сонгуулийн үйл явцыг хэрхэн удирдан зохион байгуулж байгааг анхааралтай ажиглах шаардлагатай болдог.

### **Саналаа гаргахдаа сонгогч таны зүгээс анхаарах зүйл:**

- Нэрсийн жагсаалттай танилцаж, өөрийн нэр бүртгэгдсэн эсэхийг шалгаж, сонгогчийн үнэмлэхээ авах
- Санал авах өдөр 07 цагаас 22 цаг хүртэл хугацаанд санал авах байранд ирж, саналаа өрөө гаргах
- Иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичгийг нэрийн жагсаалттай тулгаж, саналын хуудсаа авч, түүнд гарын үсэг, тамга тэмдэг байгаа эсэхийг болон хуудсыг хүчингүй болгох өөр ямар нэгэн тэмдэглэгээ байгаа эсэхийг анхааралтай ажиглах
- Саналын хуудсаа авч санал бэлтгэх тасалгаанд орж, уг хуудсанд бичигдсэн нэр дэвшигчдийн дотроос өөрийн сонгохыг хүссэн мандатын тооноос хэтрэхгүй нэр дэвшигчийн овог, нэрийн өмнөх дугаарыг дугуйлан тэмдэглээд санал хийх
- Хувь тэнцүүлсэн тогтолцооны саналын хуудсанд бичигдсэн нам, эвслийн нэрийг тэмдэглэж саналаа өгнө.
- Саналаа тэмдэглэхдээ алдаа гаргаж буруу тэмдэглэвэл уг саналын хуудсаа санал тоолох төхөөрөмжид хийхээс өмнө хэсгийн хороонд энэ тухайгаа мэдэгдэж хуудсаа хураалган дахин нэг удаа саналын хуудас авах
- Саналын хуудсанд саналаа өөрөө тэмдэглэж чадахгүй бол өөрийн итгэмжилсэн хүний туслалцаа авах
- Харин биеийн эрүүл мэндийн болон бусад шалтгааны улмаас санал авах байранд хүрэлцэн ирж чадахгүй бол хүсэлт гарган битүүмжилсэн хайрцгаар саналаа өгөх

*Өөрийн хайхрамжгүй байдлаас алдаа гаргаж, саналаа хүчингүй болгож болзошгүй. Учир иймд саналын хуудсан дээр буй саналаа хэрхэн тэмдэглэх тухай заавартай танилцах нь чухал.*

## **Сонгогч та ухуулагчдын арга зальд автагдалгүй бие даасан ухаалаг сонголт хийхдээ дараах 10 санамжийг анхаарч үзээрэй.**

1. Сонгуулийн хэсэг рүү очиж явахдаа “өөрийн сонголт өөртөө зөв” гэдгийг бүү март. Бие даасан сонголт хийхэд зөвхөн энэ л танд тус болно.
2. Саналын хуудсыг анхааралтай уншигтун. Бүү яар. Бодох хугацаа бий.
3. Хэрвээ ухуулагчид танд мөнгө, архи дарс, ямар нэгэн бэлэг өгөхийг оролдвол “энэ бол түгшүүрийн дохио” гэж бод. Үнэгүй өгөөш зөвхөн хулганын занганд байдгийг санагтун.
4. Гадаад өнгөнд бүү хуурт. Гадарлах бус доторло. Уг үндсийг нь уудалж үз. Нэр дэвшигчдийн хүчтэй сүржин үг яриа, том том сайхан амлалтуудад самуурч болохгүй. Энэ хүн улс орныхоо төлөө, бас таны төлөө бодитой ямар зүйл хийж чадахыг цэгнэж бодогтун.
5. Хэрвээ та ухаалаг сонголт хийхийн тулд цаг зав, хөлс хүч гаргахыг хүсэхгүй бол дараа нь хэн ч таны төлөө анхаарал тавихгүй гэдгийг ухаарагтун. Таны санал жин дарахгүй ч төрийн эрх мэдлийн нэгээхэн хэсэг мөн. Гэвч үүнээс таны ирээдүй төдийгүй, хэнээр хэрхэн засаглуулах тань ихээхэн хамаардгийг санаж явагтун.
6. “Бүх нэр дэвшигчдийн эсрэг” санал бүү гаргагтун. Энэ бол та ухуулагчдын арга зальд автагдаж, сонголт хийж чадахгүй байгаа хэрэг. “Боломжийн хүн”-ийг хайгтун.
7. Ухуулагчдын элдэв ятгалгад бүү авт. Танд өөрийн сонголт байгааг тэдэнд батлан харуулагтун.
8. Ухуулагчид таны “тархийг угаах”-ыг завдаж болзошгүй тохиолдолд санамжуудаа эхнээс нь дахиад нэг удаа уншаарай.
9. Хэрвээ та муу санаатай, башир аргатай ухуулагчдын тавьсан занганд ороогүй бол ухаалаг, бие даасан сонголт хийхээр биеэ бэлтгэхэд цаг заваа дэмий үрээгүй гэсэн үг. Танд баяр хүргэе.
10. Биеэ мэдвэл хүн гэдэг. Өөрөө өөрийгөө мэдэж, өөрийнхөөрөө сонголт хийж амьдрагтун.

## **СОНГОГЧДЫН САНАЛЫН ХУУДСЫГ ТООЛОХ ТӨХӨӨРӨМЖ**

### **Санал тоолох төхөөрөмж**

- Уг төхөөрөмж нь Канад улсад үйлдвэрлэгдсэн.
- Нийт 2500 ширхэг төхөөрөмж байгаа бөгөөд 2000 санал авах хэсэгт тараагдана.
- Нөөцөнд, болзошгүй эвдрэл гарсан тохиолдолд 500 ширхэг бэлэн байдалтай байна.

### **Санал тоолох төхөөрөмж хэрхэн ажилладаг вэ?**

- Саналын хуудсыг уншиж зураг хэлбэрээр сканнердан хуулж аваад хайрцагт хадгална.
- Санах ойн мэдээллийг боловсруулан сонгуулийн дүнг хэвлэж гаргахаас гадна зурган байдлаар ажиглагч нарт хувилж өгнө.
- Гаргасан дүн ажиглагчийн дүнтэй зөрүүтэй байвал төхөөрөмжийг нээж саналын хуудсуудыг гар аргаар дахин тоолох боломжтой.
- Орон даяар нэг цагт саналын дүнг Мэдээлэл Технологийн Үндэсний төв рүү нууцлал бүхий код ашиглан дамжуулна.
- Энэ хугацаа маш богино байх бөгөөд хакердах зэргээр дүнд нөлөөлөхөд амжихааргүй бага хугацаа юм.



### **Саналын хуудас**

- Энэ удаагийн сонгуулийн саналын хуудас ар өвөргүй хэлбэртэй байна
- УИХ-ын сонгууль, Аймаг, Нийслэлийн ИТХ-ийн сонгууль гэсэн хэсгээс бүрдэнэ.
- Сонгосон нэр дэвшигчийн харалдаа байрлах нүдэн хэсгийг зориулалтын балаар бөглөнө.

### **Анхаарах зүйлс**

- Санал тэмдэглэх зааварчилгаатай танилцаж, зааврын дагуу саналаа тэмдэглэх.



- Саналын хуудсыг яаралгүй, анхааралтай унших.
- Зориулалтын бус балаар бөглөх, саналын хуудсан дээр гарын үсгээ зурах болон өөр янз бүрийн тэмдэглэгээ хийвэл саналын хуудасыг хүчингүйд тооцно.
- Буруу тэмдэглэгээ хийсэн тохиолдолд саналын хуудсыг солиулан авч дахин саналаа өгч болно.
- Сонгогч нь зөвхөн оршин суух хаягийн дагуу бүртгэлтэй сонгуулийн байранд очиж саналаа өгнө.
- Сонгууль болохоос 60 хоногийн өмнө орон даяар шилжилт хөдөлгөөнийг бүрэн зогсоодог.

**Сонгогчид дор дурьдсан үйлдэл, үйл ажиллагаа явуулахыг хуулиар хориглосон байна.**

**Үүнд:**

- Тухайн санал авах байранд саналаа өгөх эрхгүй гэдгээ мэдсээр байж санал өгөх,
- Өөр хүний бичиг баримт, эсвэл хуурамч бичиг баримт ашиглах зэргээр санал өгөх, санал өгөхийг оролдох, хуурч мэхлэх;
- Тухайн хэсгийн хорооноос олгосноос өөр саналын хуудсыг санал өгөхөд ашиглах,
- Санал авах байранд гаднаас саналын хуудас авч орох, санал авах байрнаас саналын хуудас авч гарах;
- Саналын хуудсанд тэмдэглэсэн саналаа баталгаажуулан зураг авах, дүрс бичлэг хийх зэрэг үйлдэл хийх;
- Саналын хуудсанд хийсэн тэмдэглэгээгээ бусдад харуулах;
- Аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн төлөө санал өгөхийг, эсвэл өгөхгүй байхаар амлалт авах,
- Мөнгө, эд зүйл шаардах, авах.

Дээр дурьдсан зөрчилийг гаргасан иргэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 14 хоногийн хугацаагаар баривчлах захиргааны шийтгэл ногдуулахаар хуульчилжээ.



## МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО

Ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал хурааж дуустал аливаа этгээд **сонгогчдын саналыг татах зорилгоор ДАРААХ ҮЙЛДЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХЫГ**

# ХОРИГЛОНО!

Сонгуулийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1 дэх хэсэг



**Мөнгө, эд зүйл тараах**



**Бараа, эд зүйл хөнгөлөлттэй үнээр худалдах**



**Аливаа үйлчилгээ төлбөргүйгээр болон хөнгөлөлттэй үзүүлэх**



Нийтийг хамарсан биеийн тамирын уралдаан, тэмцээн, баяр наадам, урлагийн тоглолт, хүлээн авалт, дайллага, цайллага, төлбөрт таавар, бооцоот, мөрийтэй тоглоом зохион байгуулах, ивээн тэтгэх



Сонгогчдыг гадаад, дотоодод аялал зохион байгуулан оролцуулах, амралт, сувилалд амрах, сувилуулах



Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орон зай, мессеж ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт зохион байгуулах, бусдыг гүтгэн доромжлох, хуурамч мэдээлэл тараах



Ирээдүйд өөрийн болон бусдын хөрөнгөөр мөнгө, эд бараа өгөхөөр гэрээ байгуулах, хэлцэл хийх



**Амлалт**

Хишиг, хувь, хувьцаа өгөх, ажлын байранд зуучлах, ажилд оруулах зэрэг амлалт авах

## ЗУРГАА. НУТГИЙН УДИРДЛАГА

*Төрийн эрх мэдлийг нутгийн иргэдэд ойртуулж, өөрсдийн хамтын амьдралыг зохицуулах боломж, хэм хэмжээг бүрдүүлсэн.*

*Төрийн эрхийг барихад иргэдийн оролцоог баталгаажуулсан.*

*Шийдвэр гаргах үйл явцыг илүү нээлттэй, олон нийтэд ойр дөхөм болгосон.*

*Улс төрийн эрх мэдлийг удирдлагын өөр өөр түвшинд хуваарилж өгснөөр засаглалыг хянах, эрх мэдлийг хязгаарлах боломж бүрдэнэ.*

*Иргэдэд өөрийн орон нутгийн асуудлыг өөрсдийн санаачлагаар хамтран шийдвэрлэх, зохион байгуулах, хариуцах боломж бүрдэнэ.*

### **Нутгийн өөрөө удирдах ёс гэж юу вэ?**

Олон түмэн улс төрийн хэрэгт эрх тэгш, чөлөөтэй оролцох бололцоо нөхцөл Монголын түүхийн аль ч үед өнөөдрийнх шиг ийм нээлттэй байсангүй. 1992 онд батлагдсан ардчилсан үндсэн хууль анх удаа ийм боломж олгосон билээ.



Нутгийн өөрөө удирдах ёсыг /НӨҮЁ/ хүлээн зөвшөөрч, түүнийг жинхэнэ ёсоор хөгжүүлснээр хувь хүн эрх, эрх чөлөөтэй болж нийгэмд идэвхтэй оролцон амьдрах гэсэн мэдрэмжийг нь бадрааж өгдөг.

Орон нутгийн түвшинд тус тусдаа бодлого боловсруулж хэрэгжүүлэх үүрэг хариуцлагаа хүлээсэн хэвтээ тэнхлэгийн ижил статустай иргэдийн олон Хурлууд зэрэгцэж орших нь нэг талаараа өрсөлдөөний хөгжлийг, нөгөө талаар өрсөлдөөнт хөгжлийг, бас хэвтээ тэнхлэгтээ нэгдэж бие биенийгээ тэтгэн хамтарч ажиллах эрмэлзлэлийг төрүүлдэг.

**“Нутгийн өөрөө удирдах ёс”** хэмээх нэр томъёо нь сонгуулиар байгуулагдсан, ардчилсан шинж бүхий орон нутгийн удирдлагын байгууллага гэсэн санааг илэрхийлдэг. Ийм учраас нутгийн өөрөө удирдах байгууллагыг орон нутгийн түвшний үйл явц, үр дүнг тухайн нутаг дэвсгэрт мөрдөгдөж байгаа хэм хэмжээ, тогтсон журмын дагуу, орон нутгийн байгууллагууд нь өөрсдөө бие даан, нийгэм, эдийн засаг, улс төрийн утга агуулгаар нь шийдвэрлэх институциональ ардчилсан тогтолцоо гэж тодорхойлно. “Нутгийн удирдлагын байгууллага” болон

“нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага” гэсэн нэр томъёо нь ардчилсан сонгуулиар сонгогдсон орон нутгийн засаглал гэсэн утга санааг илэрхийлнэ.

Энэ бол өөрийн удирдлага, тусгай нутаг дэвсгэр бүхий хурлууд нь төрийн удирдлагын ардчилсан хэлбэрийн нэг чухал үндэс, эрх мэдэл, удирдлагын жолоо, цулбуур дан ганц төрд төвлөрөхөөс зайлсхийх нэг чухал нөхцөл юм.

Нутгийн өөрөө удирдах ёс нь иргэддээ үйлчилж, орон нутгийн төрийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэнэ.

*Гэтэл өнөөг хүртэл нутгийн захиргааны нэгжүүд буюу аймаг, хот, сум, дүүрэг, баг, хороог шийдвэр гарган хэрэгжүүлэгч бус, зөвхөн дээрээс ирсэн шийдвэрийг хэрэгжүүлэгч эсвэл түүнийг доош нь дамжуулагч төдий л үздэг сэтгэлгээ амь бөхтэй хэвээр байна.*

НӨУЁ-ыг бэхжүүлэх нь төвлөрлийг сааруулах гэдэг нь орон нутгийн амьдралын үндсэн асуудлыг төв засгийн газар, түүний яамд шийддэгийг задалж, орон нутагт шийдвэр гаргах, түүнийгээ хэрэгжүүлэх эрх олгох явдал юм. Гэхдээ энэ нь өөрийн гаргасан шийдвэрээ хэрэгжүүлэх хөрөнгө мөнгийг өөрийн төсвөөс бүгдийг гаргана гэсэн хэрэг бус, харин орон нутгийн үйл ажиллагааны эрх хэмжээг улам нарийсгахыг шаарддаг.

Нутгийн өөрөө удирдах байгууллага нь зөвхөн улс төрчдийн хувьд төдийгүй энгийн иргэдийн хувьд төрийн үйл ажиллагаанд оролцох, хянах, улмаар ардчилалд суралцах сургууль болдог улс төрийн бие даасан институт юм. Өөрийн эрх хэмжээний хүрээнд иргэдийн улс төрийн оролцоог тэлэх өргөн боломжийг энэхүү нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага агуулна.

## **Нутгийн өөрөө удирдах ёсны зарчмууд**

Нутгийн өөрөө удирдах ёсны зарчим гэдэг нь тухайн удирдлагыг хуулийн хүрээнд хамгийн зохистойгоор хангахад чиглэгдсэн бодлого, чиглэл, баримтлал юм.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь:

- Нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ асуудлыг бие даан зохион байгуулах,
- Ардчилсан ёсыг хангах,
- Шударга ёсыг дээдлэх
- Эрх чөлөө, тэгш байдлыг хангах,
- Үндэсний эв нэгдлийг хангах зэрэг зарчмуудтай.

## Монгол Улсын Үндсэн хуулийн Нутгийн удирдлагын тухай үзэл баримтлал



### **Нутгийн удирдлага дахь иргэдийн оролцоо. Баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурал /ИНХ/**

Иргэдийн Нийтийн Хурал бол орон нутгийн ардчиллын бодит баталгаа мөн. Энэ бол шууд ардчиллын хэлбэрийн биелэл юм. Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан. Нийтийн Хурлын хуралдаанд тухайн баг, хорооны сонгуулийн насны /18 насанд хүрсэн/ иргэн бүр оролцож болно. Хуралдааныг багт 3 өрх тутмаас сонгуулийн насны нэг хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно. Нийтийн хурлын хуралдаан нь орон нутгийн ардчиллыг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд энэ нь дараах зарчимд тулгуурлана. Үүнд:

- Иргэн бүр хуралд асуудал шийдвэрлэх эрхтэйгээр оролцох,
- Шийдвэрийг эцэслэн батлахдаа олонхийг дагаж, цөөнхийг хүндэтгэх,
- Хурлаар хэлэлцэх асуудал нээлттэй бөгөөд шийдвэр гаргах боломжтой байх,
- Дэвшүүлсэн зорилгоо хангахуйц үр дүнтэй байх,
- Үүргээ ухамсарласан буюу хариуцлагатай байх зэрэг болно.



**Баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурал  
ямар эрх мэдэлтэй вэ?**

**Баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурал бол нутгийн өөрөө удирдах байгууллагын анхан шатны нэгж мөн бөгөөд дор дурдсан эрх хэмжээг хуулийн дагуу эдэлж хэрэгжүүлнэ. Үүнд:**

1. Баг, хорооны Засаг даргыг томилуулахаар нэр дэвшүүлэх, чөлөөлүүлэх, огцруулахаар сум, дүүргийн Засаг даргад санал тавих,
2. Хурлын дотоод зохион байгуулалтын асуудал хэлэлцэн шийдвэрлэх,
3. Шаардлагатай гэж үзвэл Засаг даргын ажлын тайланг сонсох,
4. Баг, хорооны иргэдийг шагнаж урамшуулах, тусламж үзүүлэх,
5. Өрхийг албан татвар, бусад ногдол үүргээс түр чөлөөлөх буюу хөнгөлөлт үзүүлэхээр санал тавих,
6. Иргэний үндсэн болон журамт үүргийн биелэлтийг хангуулах,

**Баг, хорооны Засаг даргыг томилуулахаар нэр дэвшүүлэх, чөлөөлүүлэх, огцруулах санал тавихаас бусад эрх хэмжээг хуралдааны чөлөөт цагт Хурлын Тэргүүлэгчид эдэлнэ.**

Хууль зүйн хувьд НӨУЁ нь дараах онцлог шинжтэй бөгөөд эдгээрийн аль нэг нь үгүй бол жинхэнэ утгаараа хэрэгжиж чадахгүй юм. Үүнд:

- а. Тухайн орон нутгийн өөрсдийн аж амьдралын асуудлыг хуулийн хүрээнд өөрсдөө бие даан шийдвэрлэдэг.
- б. Тэрхүү шийдвэр нь тухайн хамт олонд тэдний оршин амьдрах нутаг дэвсгэрийн хэмжээнд заавал биелүүлэх хүчинтэй байна.
- в. Шийдвэрээ биелүүлэхдээ гаднын дарамтад автахааргүй бие даасан байхуйц хууль зүй, эдийн засаг, зохион байгуулалттай байх зэрэг онцлог шинжүүд бий.

*Орон нутгийн эрх мэдлийг хумих бус, харин түүний шийдвэр гаргах, түүнийгээ өөрийн боломжоор хэрэгжүүлэх чадавхи нь хамгийн чухал юм.*

Гэвч сум, аймгаараа цуглараад байх боломжгүй учир тэдэнд өөрсдийн төлөөлөгчдийн хийгээд түүний хураангуйлсан байгууллага, бас ажлын мэргэшсэн алба зайлшгүй хэрэгтэй болдог. Энэхүү бодит шаардлагыг

харгалзан Үндсэн хуулиар баталгаажсан НӨУЁ-ны гурван үндсэн хэлбэр буй. Энэ нь:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ
2. Баг, хорооны ИНХ
3. ИТХ-ын ба ИНХ-ын тэргүүлэгчид юм.

ИТХ, ИНХ бол төрийн ч биш, олон нийтийн ч бус харин Үндсэн хуулийн биеэ даасан институци мөн. Энэ нь дараах шинжээр илэрнэ. Үүнд:

- o ИТХ, ИНХ нь зөвхөн төрийн чиг үүргийг бус харин иргэдийн өмнөөс өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлдэг. Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 1.-д “хурал нь нутаг дэвсгэрийн хэмжээний асуудлыг бие дааж шийдвэрлэх, улсын чанартай шийдвэрлэхэд хүн амыг оролцуулах” гэсэн нь ӨУЁ-ны болон төрийн чиг үүргийн заагийг тогтоосон хэрэг мөн.
- o Төрөөс хууль тогтоолоор бус иргэд өөрөө сонгож байгуулдаг. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, багийн ИТХ, ИНХ-ыг байгуулах сонгууль 1992 оноос хойш явагдаж ард иргэд сонгуулийн ардчилалд зохих хэмжээгээр суралцаж байна.
- o ИТХ, ИНХ нь зөвхөн тухайн нэгжийн иргэдийн дотроос сонгогдсон төлөөлөгчдөөс бүрдэнэ.

ИТХ, ИНХ нь бүрэн эрхийн хувьд тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэр, нэгжийн **эрх барих байгууллага** мөн. Энэ бол орон нутаг дахь төрийн эрх барих байгууллага гэсэн үг биш. Харин иргэдийн өөрсдийнх нь олгосон бөгөөд Үндсэн хуулиар баталгаажуулсан бүрэн эрхийн хувьд нэгжид оршин суугаа бүх хүн амыг засаглах бүрэн эрхтэй байгууллага гэсэн үг.

### **Орон нутгийн үйл ажиллагааны хэм хэмжээ**

Орон нутгийн хөгжлийн түвшинг дээшлүүлэхэд нутгийн захиргааны нэгжийн гүйцэтгэх үүрэг нь дараах хүчин зүйлсээр тогтоогдоно.

Үүнд:

- o **Эрх зүйн хэм хэмжээг тогтоох боломж.** Үүнд орон нутгийн захиргаад өөрийн хөгжлийн бодлогыг тогтоон хэрэгжүүлэх, үүний биелэлтийн эрх зүйн орчныг бүрдүүлэх чадавхи хамаардаг.
- o **Боловсон хүчний боломж.** Боловсруулсан бодлогоо өөрийн үзэмжээр хэрэгжүүлэх эсэх нь юуны өмнө төрийн албаны чадвар, орон нутгийн захиргааны ажлын далайцаар шийдэгдэнэ.

- **Удирдлагын бие даах боломж.** Энэ нь нэг талаасаа үндэсний хэмжээнд Засгийн газар, Парламентын бий болгосон эрх зүйн орчноор тогтоогдох боловч боловсруулсан бодлогоо өөрийн нөөц бололцоогоор хэрэгжүүлэх боломж өргөсөх тусам орон нутгийн бие даах нөхцөл хангагдана.

**Баг, хорооны засаг дарга ямар үүрэгтэй,  
Таны төлөө юу хийх ёстой вэ?**

**Баг, хорооны Засаг дарга бол баг, хорооны ийн хөдөлмөрчид, иргэдийн эрх, эрх чөлөөг хангуулах, ашиг сонирхлыг нь хамгаалахад чухал үүрэг хүлээнэ. Засаг даргын хариуцдаг ажил, чиг үүргүүд:**

- Эрх хэмжээнийхээ дотор нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд үүрэг даалгавар өгч, бэлтгэлийг хангуулах,
- Тухайн нутаг дэвсгэрт байгаа байгалийн баялаг, ан амьтан, хадлан бэлчээр, тариалангийн талбайн ашиглалт, хамгаалалтын байдалд хяналт тавих,
- Гачигдалтай иргэдэд дэмжлэг тусламж үзүүлэх,
- Хууль тогтоомж, дээд шатны байгууллагын тогтоол, шийдвэрийг багийн иргэдэд мэдээлэх, түүнийг биелүүлэх ажлыг зохион байгуулах,
- Иргэдэд суурь боловсрол эзэмшүүлж байгаа байдалд хяналт тавьж, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, бүх төрлийн үйлчилгээг хөгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх,
- Иргэдийн санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, дээд байгууллагад уламжлах,
- Байгууллага, иргэд хууль тогтоомж, дээд шатны байгууллагын шийдвэр хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих гэх мэт.

- **Санхүүгийн бие даасан байдал.** Аливаа улс оронд, ямарваа тохиолдолд өөрийн орон нутгийн төсвийн орлогоор зардлаа бүрэн төлдөг, төвлөрсөн төсвөөс хамаардаггүй орон нутгийн төсөв байхгүй юм. Харин ямар түвшинд орон нутаг өөрийн бодлогоо хэрэгжүүлэх санхүүгийн нөөцийг бүрдүүлдэг нь түүний санхүүгийн хараат бус байдлыг тогтоож өгдөг. Өөрөөр хэлбэл, төвлөрсөн төсвөөс бага хамаарах тусам л санхүүгийн чөлөөт шийдлийн орон зай их байна.



- o **Төлөвлөлтийн хараат бус байдал.** Ихэнх оронд нутгийн өөрөө удирдах ёсны нэг шалгуур нь өөрийн нөөцийн хүрээнд төв Засгийн газраас хараат бусаар бие даасан хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх явдал байдаг. Энэ нь зарлагыг бүрэн санхүүжүүлэхгүй боловч орон нутгийн эрх хэмжээнд хамаарах асуудлыг төвөөс хамааралгүйгээр төлөвлөх боломжтой эсэх тухай асуудал юм.

*Орон нутгийн эрх мэдэл хэрхэн хэрэгжих нь түүний эрх зүйн хэм хэмжээг тогтоох боломж болон боловсон хүчин, удирдлага, төлөвлөлт, санхүүгийн бие даасан байдлаас шууд хамааралтайг хаа хаанаа анхаарах шаардлагатай байна.*

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 1.-д “Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэнэ...” гэж заасан байдаг. Ийнхүү удирдлагын болон төлөвлөлтийн бие даасан байдлыг хуульчилсан хэдий ч өнөөгийн нөхцөлд хэт жижгэрсэн орон нутгийн нэгжид өөрийн чадавхиар аливаа асуудлыг шийдэх боломж хязгаарлагдмал хэвээр байна.

**Баг, хорооны Засаг даргын шийдвэр нь хууль зөрчсөн буюу хүний эрхийг хохироосон гэж үзвэл Та хаана хандах ёстой вэ?**

Засаг даргын бүхий л үйл ажиллагаа хуулийн хүрээнд явагдах ёстой. Засаг дарга эрх хэмжээнийхээ дотор хууль тогтоомжид нийцүүлэн захирамж гаргана. Хэрвээ Засаг даргын захирамж хууль зөрчсөн буруу шийдвэр боллоо хэмээн үзэж үл зөвшөөрсөн тохиолдолд тухайн асуудлыг сум, дүүргийн Засаг даргад шууд хандаж шийдвэрлүүлж болно. Түүнчлэн багийн Засаг даргын хууль бус шийдвэрийг биелүүлэх явцад хүний эрх зөрчигдсөнөөс үүссэн хэрэг, маргааныг сумын буюу сум дундын шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргах замаар шийдвэрлүүлж болно.

**Баг, хорооны Засаг дарга нь**

**Хүний эрхийн талаарх олон улсын гэрээ, хэлэлцээр, хууль тогтоомжийг багийн иргэдэд сурталчлах, мэдээлэх, иргэдийн эрх зөрчигдсэн тухай номдлыг өөрийн харъяаллын хүрээнд шийдвэрлэх зэрэг чиг үүрэгтэй. Түүнээс гадна шаардлагатай гэж үзсэн зарим асуудлыг сум, дүүрэг, аймаг, нийслэлийн төр, захиргааны байгууллагад уламжлах, шүүх, хуулийн байгууллагад хүсэлт тавих, хууль зүйн асуудлыг шийдвэрлэх замаар үйл ажиллагаагаа явуулна.**

Монгол Улсын 21 аймаг, 340 гаруй сум, 1634 баг бүхий засаг захиргааны өнөөгийн бүтэц нь үндэсний хэмжээнд ч, орон нутгийн түвшинд ч “хөгжлийн гацаа” үүсгэж байгаа юм.

*Засаг захиргааны нэгж жижгэрэх тусам иргэдэд хүрэх үйлчилгээний чанар сайжирч, жинхэнэ хэрэгцээт иргэддээ хүрдэг гэсэн үзэл баримтлалыг зарим судлаачид дэвшүүлэн тавьдаг ч манай орны хувьд энэ нь харин эсрэгээрээ үйлчилж байна гэж бас үзнэ.*

Дээрх байдлаас эрс шийдвэртэй татгалзаж өөрийгөө тэтгэх чадавхитай эдийн засагтай байхын тулд юуны өмнө нутаг дэвсгэрийн эдэлбэр газрыг шат шатны хуралд нь хуваарилан эзэмшүүлэх шаардлага нутгийн удирдлагын байгууллагын өмнө тулгарч байна.

## ДОЛОО. АРДЧИЛЛЫГ АЛДАЖ БОЛДОГ, АЛДАХГҮЙН ТУЛД ЯАХ ЁСТОЙ ВЭ?

Ардчиллын хөгжилд ХХ зуун онцгой байр суурь эзэлнэ. Энэ зуун бол ардчиллын үзэл санаа түгэн дэлгэрч, сая сая хүний оюуныг эзэмдсэн зуун болжээ. 1900 он гэхэд ардчиллыг цогцоор нь хэрэгжүүлсэн нэг ч улс байгаагүй ба ардчиллын үзэл санааны үр шимийг дэлхийн хүн амын зөвхөн 12,4 хувь буюу 206,6 сая хүн хүртэж байсан бол зуун жилийн дараа 2000 он гэхэд энэ тоо тав дахин өсч, өнөөдөр ХХI зуунд дэлхийн хүн амын 62,5 хувь нь ардчиллын нөхцөлд амьдарч байна.

Монгол Улс өнөөдөр ардчилсан хөгжлийг сонгож авснаас хойш арав гаруй жил замнаж буй боловч ардчиллын хөгжлийн төвшний хувьд бид хаана явна, ардчиллыг улам баталгаажуулахын тулд юунд анхаарах ёстой зэрэг асуудлыг авч үзье. Үүнд:

1. Монгол Улсад ардчилал цаг хугацааны хувьд 1989-1990 оны заагаас эхэлсэн түүхтэй. 1990 оны долдугаар сард анхны чөлөөт сонгууль явагдаж үүний үр дүнд Ардын Их Хурал, Улсын Бага Хурал, шинэ Засгийн газар бий болсон. Эдгээр төрийн эрх барих дээд байгууллагын бүтэц дотроос Улсын Бага Хурлын Монгол улсад ардчилал хөгжихөд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж Монгол Улсын шинэ Үндсэн хууийн төслийг боловсруулжээ.
2. Сонгууль явуулахын утга учир, бүх нийтийн чөлөөт сонгуулиар өөрийн үзэл бодол, хүсэл сонирхлоор сонголт хийх эрх нь хувь хүний салшгүй эрх гэдгийг монголын ард түмэн 1990 оноос ойлгож эхэлсэн юм.
3. 1990 оны анхны чөлөөт, олон намын оролцоо бүхий сонгуулиас хойш эдүгээг хүртэл Монгол Улсын Ерөнхийлөгчийн зургаа, 1990 оны Ардын ИХ хурал, Улсын Бага Хурал, Улсын Их Хурлын долоо болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын зургаан сонгууль тус тус болж өнгөрлөө. Эдгээр сонгууль нь бүх нийтийн, чөлөөт, шууд, нууц байх зарчмаар явагдаж, сонгуулийн дүнгээр дөрвөн жилийн хугацаанд иргэдийн хүсэл зоригийг тээсэн төр засаг байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж иржээ. **Ийнхүү Монгол Улсад өрсөлдөөний замаар, олон нийтийн сонгуулийн дүнд, олонхийн санал авсаны үндсэн дээр тодорхой бие хүмүүс улс төрийн шийдвэр гаргах эрх мэдэлд хүрдэг систем бодит зүйл болсоор байна.**



Энэ бүгд нь ардчилалд шилжиж буй бусад орны нэгэн адил Монгол Улсын ардчилалд шилжин орох эхний алхмууд зөв гольдиролоор явж ирснийг илтгэнэ. Үүнээс гадна:

1. Нэг намын ноёрхол бүхий улс төрийн системийг баталгаажуулж байсан эрх зүйн системийг үндсээр нь өөрчилсөн. Төрийн эрх барих дээд байгууллага – Ардын Их хурал 1991-1992 оны зааг дээр шинэ **Үндсэн хуулийн төслийг шүүн хэлэлцэж баталснаар 1990 оноос эхэлсэн Монгол Улсын ардчилсан хөгжлийн эрх зүйн үндсийг тавьсан.**
2. Улс төр, эдийн засгийн суурь өөрчлөлтийн бодлого хэрэгжүүлж эхэлснээр нийгэмд эрх ашиг, сонирхол бүхий бүлгүүд аажмаар үүсч, олон ургальч үзэл хөгжих эхлэл тавигдсан. Энэхүү олон янзын сонирхол, хүсэл зориг нь нийгэмд өрсөлдөөнийг тэтгэгч болсоор байна.
3. Төрийн эрх мэдлийг хуваарилах зарчмууд үйлчилж эхэлсэн.
4. Хувь хүн бүр төрийн байгууллагад сонгогдох эрх Үндсэн хуулиар хангагдсан.
5. Төрөө эмхлэн байгуулахын зэрэгцээ төрийн түшээдтэй хариуцлага тооцож халж солих сонгогчдын эрх, үүрэг бодитой болж, сонгогчид энэ талаар “туршлагатай” болсоор байна.
6. Сонгогчдын саналаа өгөх нь эрх баригчдыг сонгохтой холбоотой бөгөөд өрсөлдөж буй хувь хүн, бүлгээс илүү их санал цуглуулж, илүү дэмжлэг хүлээсэн этгээдэд төрийн эрх мэдэл шилждэг ардчилсан зарчим ердийн үзэгдлийн хэмжээнд үйлчилдэг болсон.

Монгол дахь ардчиллын өнөөгийн хөгжлийн түвшний ерөнхий дүр зураг

1. 1990 оны анхны чөлөөт сонгуулиас хойш төрийн эрх мэдэл ард түмнээс эх сурвалжтай байх зарчим хэрэгжиж, **улс төрийн хөгжлийн хэвийн, тогтвортой байдал хадгалагдсаар байна.** Сонгуульд оролцох, иргэдийн идэвх өндөр, санал өгч буй сонгогчдын хувь харьцангуй өндөр, намуудын улс төрийн өрсөлдөөн, өөрсдийгөө сурталчлан таниулах боломж нээлттэй, төрийн зүгээс сонгууль зохион байгуулах бүтэц, үйл ажиллагаа олон намын системийн шаардлагыг хангаж байгаа зэрэг нь өнгөрсөн үеийн сонгуультай харьцуулшгүй чанарын өөр түвшинд очжээ.
2. Төр нь ард түмний хүсэл зоригийг хэрэгжүүлэх чиглэлд үйлчлэх чиг үүрэгтэй бөгөөд үүнийг Үндсэн хуулиараа баталгаажуулсан.

Зах зээлийн эдийн засгийн үйлчлэлтэй холбоотойгоор иргэдийн аж амьдралын хэв маяг, онцлог, арга хэлбэр өөр өөр байхаас гадна нийгэмд хэвшиж буй олон ургальч байдлаас хамаарч үзэл бодол, хүсэл сонирхлын ялгарал бий болж байна. Энэ бүгд нь монголын нийгмийн бүтэц дэх ялгарлыг аажмаар нөхцөлдүүлж байгаа ба үүний үр дүнд нийгмийн давхраажилт 1990 оноос эрс өөрчлөгдөж эхэлсэн.

Нийгэм дэх олонлог сонирхолд тулгуурласан зохион байгуулалтанд орох, эрх ашгаа илэрхийлэн хамгаалах үүднээс иргэд эвсэн нэгдэж, төрийн бодлогод өөрийн эрх ашгийг тусгуулах, шахалт үзүүлэх, асуудал дэвшүүлэн тавих зэрэг эрхээр хангагдлаа.

*Гэвч амьдрал дээр Үндсэн хуулинд тусгалаа олсон эдгээр эрхийн хэрэгжиж буй байдал хэвийн бус, нийгмийн зүгээс шийдвэр гаргагчдыг хянах байтугай тэдэнд нөлөөлөх явдал сонгуулиас бусад үед хязгаарлагдмал хэвээр байна.*

3. Тоталитар, авторитар нийгэмд төр нь эрх баригч хүчний үзэл суртал, хүслийг хангагч “аппарат, машин” болж байдаг бол ардчилсан нийгэмд ард нийтэд үйлчлэх чиг үүрэгтэй байдаг. Үүнийг хэрхэн хангаж, хянаж зохицуулж байгаагаар ардчиллын хөгжлийн түвшинг тодорхойлдог.

Төрийн үйл хэргийг аль нэг субъектийн хараа хяналтанд захируулахгүйн үүднээс төрийн эрх мэдлийг хуваарилах үзэл баримтлал Монгол улсын Үндсэн хуулийн төрийн байгуулалтын системийг тодорхойлох суурь нь болсон юм. Төрийн үйл хэрэг, гаргаж буй шийдвэр нь эцсийн бүлэгтээ ард нийтийн ач тусад үйлчлэхээр Үндсэн хуулинд оруулсан бөгөөд төр энэхүү үүргээсээ хазайх тохиолдолд нийгэм болон тодорхой иргэдэд

хохирол учруулдаг байна. Энэ байдлыг төр өөрөө хянах үүднээс хараат бус, хэн нэгэнд автагдахгүй, бие даасан байх хуулийн хамгаалалт бүхий шүүх эрх мэдлийг онцгойлон тавьдаг.

Ардчилсан нийгэмд шүүх нь хүнийг аливаа халдлага, тэр дотроо төрийн буруу халдлагаас хамгаалах гол институт болдгоороо бусад дэглэмээс ялгагддаг. Энэ үзэл санаа шинэ Үндсэн хуулийн нэг тулгуур нь мөн бөгөөд шүүхийн бие даасан үйл ажиллагааг хангах эрх зүйн өөрчлөлтийг эдүгээ хийж эхэлсэн. Гэвч шүүхийн шийдвэрийг өөрийн нэр төр, амин хувийн ашиг сонирхол, өөрийн нам, байгууллага, компани, найз нөхдийн ашиг сонирхолд нийцүүлэн гаргуулахыг оролдох, энэ зорилгоор хэвлэл мэдээллийг ашиглан олон түмний сэтгэл санаанд нөлөөлж, түүгээрээ дамжуулан шүүх болон шүүгчид дарамт үзүүлэх, шүүх, шүүгчийн нэр хүндийг унагаахыг оролдох явдал цөөнгүй үзэгдсээр байна. Энэ байдал олон нийтийн санаа бодолд сөргөөр тусаж өөрсдийг нь хамгаалах төрийн гол институтын талаарх үнэлгээ доогуур байгааг олон судалгааны дүнгээс харж болно.

*Эрх зүйт төрийн төлөвшилд шүүхийн өнөөгийн байдал ба түүнд өгч буй олон нийтийн сөрөг үнэлгээ таатай орчин нь болохгүй бөгөөд энэ байдал даамжирваас ардчиллын тухай ярих үндэсгүй болох билээ.*

4. Төрийн механизмыг олон нийтэд үйлчлэхэд чиглүүлэн өөрчлөхдөө төрийн албан хаагчдын статусыг хуульчилж, Үндсэн хууль болон Улс төрийн намуудын хуулиар анхлан зохицуулалт хийж байсан бол 1994 онд Төрийн албаны тухай хуулийг тусгайлан гаргасан билээ. Энэхүү хууль нь бусад улс орны түүхэнд илэрч байсан улс төр, төрийн үйл хэргийг холихгүй байх, төрийн үйлчлэл ард иргэдийн эрх ашигт захирагдан, хараат бус байх тодорхой бодлогын үүднээс хийгдсэн нь **Монголын төрийн хөгжилд эрх зүйн хувьд том алхам болсон.** Амьдрал дээр энэ хууль өнөөдөр хүчингүй болсон мэт сэтгэгдэл төрүүлэхүйц алхмыг эрх баригчдаас гаргах болсон нь улс төрийн ухралт гэж үзэхээс өөр аргагүй. Төрийн өндөрлөгт улс төрийн хүчний харьцаа өөрчлөгдөхөд төрийн мэргэшсэн албан хаагчид солигддог системийг spoil буюу “олзны” гэж нэрлэж ирсэн ба энэхүү систем ардчилсан нийгмийн хэм хэмжээнд таарахаа больсон. Үүний оронд эрх зүйт төрийн шаардлагад нийцүүлэн улс төр, төрийн албыг зааглаж төрийн мэргэшсэн үйл ажиллагааны давуу талыг илтгэсэн merit буюу “нэр хүндийн” системийг хэрэглэдэг болсон бөгөөд үүнийг Монгол

Улсын Төрийн албаны тухай хуулиар баталгаажуулсан билээ.

*Төрийн албаны тухай хуулинд сонгуулийн дүнгээр солигдох учиртай улс төрийн албан тушаалын зэрэгцээ зөвхөн чадвар, мэргэшсэн байдлаараа шалгарах төрийн албан тушаалыг заагласан байдаг боловч энэ нь эргээд холилдох, халаа сэлгээнд хуулиар хориглосон улс төрийн шалтгааныг ил, далд хэлбэрээр голлох явдал газар авах хандлагатай болсон нь **ардчиллын утга санааны нэг болох хуулийг дээдлэх, хуульд захирагдах зэрэг үнэлэмжид хохирол учруулахуйц байдалтай байна.***

Монгол Улсын өнөөгийн хөгжил дэх ардчиллын төлөвшил, хэрэгжилттэй холбоотой учирч буй саад, бэрхшээлийг ийнхүү тоймлон авч үзвэл бидэнд анхаарах асуудал цөөнгүй байгаа боловч өнгөрсөн хугацаанд **ардчиллын улс төр, эрх зүйн суурь баталгаа бий болсныг тэмдэглэх нь зүйтэй.**

Монгол Улсын улс төр эдийн засгийн хөгжлийн өнөөдрийн хүрсэн түвшний баталгаажуулах нь ардчиллын хөгжлийн эдүгээ үеийн хамгийн чухал асуудал мөн бөгөөд хөгжлийн чиглэл нь Үндсэн хуулинд тусгагдсанчлан иргэний нийгэм, эрх зүйт төрийг төлөвшүүлэх ач холбогдолт бүхий зорилготой шууд холбоотой. Ингэснээр, Монгол улс **сонгуульт ардчиллын өнөө үед бүрэлдүүлж чадсан улс төр, эрх зүйн эерэг нөхцөл байдал, давуу талд тулгуурлан нягтарсан ардчилалд хувьсан орох бүрэн боломжтой** билээ.


## **5. Монгол дахь ардчиллын хөгжлийн өнөөгийн байдал**

XX зуун дахь хүн төрөлхтний хөгжлийн гол хандлага болсон ардчилал руу Монгол улс шилжиж эхэлснээс хойш эдүгээ 26 жил болж байна.

### **Монгол дахь ардчиллын хөгжлийн талаарх үнэлгээний тойм**

А. Эдүгээ дэлхий дээр оршин буй тусгаар тогтносон 190 гаруй улс дотор Монгол Улс “чөлөөт” ангилалд багтаж байгаа ба тоон үзүүлэлтээр 2015 оны байдлаар 1,5 рейтингтэй байна. 2001 онд “хагас чөлөөт” ангилалд багтаж байсантай харьцуулбал бид том ахиц гаргажээ<sup>1</sup>. Монгол улсын энэхүү рейтинг нь хүний улс төрийн болон иргэний эрхийн хэрэгжилтийн байдлаас шууд хамаарч байгаа нь судалгаанд тод тусчээ.

<sup>1</sup> Freedom House Survey. Nations in Transition. Reports, Mongolia. [www.freedomhouse.org](http://www.freedomhouse.org)



Жич. 1,0-2,5 хүртэл бол чөлөөт (ч)  
 2,6-5,0 хүртэл хагас чөлөөт (х/ч)  
 5,1-7,0 чөлөөт бус (ч/б)

Улс төрийн эрх, эрх чөлөөнд хамаарах үзэл бодлын эрх чөлөө, түүнийгээ илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, эвсэн нэгдэх зэрэг суурь эрх чөлөө өнөөдөр саадгүй биелэгдэх боломжтой болжээ. Харин төрийн үйл хэрэгт оролцох, эрх баригчдад нөлөө үзүүлэх, хяналт тавих зэрэг эрхээ хэрэгжүүлэх боломж иргэдийн өөрсдийн нийгэмшилт болон төрийн идэвхгүй байр сууринаас төлөвшлөө олохгүй байсаар байна. Иргэний эрхийн хэрэгжилтийн байдал мөн хугацаанд 3.0-аас 2.0 хүртэл буурсан нь улс төрийн эрхийн үзүүлэлтээс хоцорч байна.

Б. Ардчиллын хөгжлийн нэг тулгуур үзүүлэлт нь тухайн улс дахь хэвлэлийн эрх чөлөөний байдал болдог. “Reporters Without Borders” (Хил Хязгааргүй Сэтгүүлчид) байгууллагын хийсэн судалгаанд дэлхийн мөн 180 гаруй улсыг харьцуулсны дотор Монгол улс багтана<sup>1</sup>. Сүүлийн жилүүдийн байдлаар Монгол улсын хэвлэлийн эрх чөлөөт байдлыг харуулсан энэ статусд өөрчлөлт ороогүй ба дундаж төвшинд байсаар байна. Ардчиллын бэхжилтэд суурь нөлөөлөл үзүүлэх хэмжээнд ойлгогддог мэдээллийн чөлөөт орчин монголд бүхэлдээ тэгш бус байдалтай байгаа нь иргэдийн хүсэл зоригоо илэрхийлэх чадамжид сөргөөр нөлөөлөхүйц байна.

<sup>1</sup> Reporters Without Borders. [www.rsf.org](http://www.rsf.org)





В. Ардчилсан нийгэмд төр нь иргэддээ үйлчлэх гол үүрэг функцтэй ба эл үйлчилгээ ил тод шаардлагад нийцэхгүй байх нь авлига дэлгэрэх гол нөхцөл болдог. “Transparency International” байгууллагын гаргадаг Авлигын индексийн дагуу Монгол улс авлигад өртсөн улсуудын тоонд багтжээ<sup>1</sup>. (арга зүйн хувьд 2011 он хүртэл 10,0 балл, 2012 оноос 100 нь авлигад өртөөгүйг илэрхийлнэ). Авлигын асуудал нь улс төр, эдийн засаг, нийгэм дэх эрүүл харилцааг бүхэлд нь доройтуулдаг ба Монгол улсын хувьд анхаарах асуудал байсаар байна<sup>2</sup>.


	Score	Rank	Number of Countries
2004	3.0	85	145
2005	3.0	85	159
2006	2.8	99	180
2007	2.8	102	180
2008	3.0	106	180
2009	2.7	120	180
2010	2.7	116	178
2011	2.7	120	183
2012	36	94	176
2013	38	83	177
2014	39	80	175
2015	39	72	169

Г. Ардчилалд шилжих үйл явцыг зах зээлийн эдийн засгийн хөгжилтэй холбож, харилцан хамааралтай байх бодлогыг баримталж байгаа нь

<sup>1</sup> Transparency International. Corruption Index. [www.transparency.org](http://www.transparency.org)

<sup>2</sup> Улс төрийн хүрээнд дэх авлигал. Судалгааны тайлан. УБ, 2002.

Монгол улсын онцлог юм. Энэ хамааралд эдийн засгийн хөгжил нь түүний эрх чөлөөний үзүүлэлтээр илэрхийлэгдэнэ. “Heritage Foundation” байгууллагын гаргадаг судалгааны дүн энэ асуудлыг харьцуулах суурь болох боломжтой. 2015 оны тайланд Монгол улс эдийн засгийн эрх чөлөөт байдлаар ахисан үнэлгээтэй гарсан ба сүүлийн арван жилийн дотор тогтвортой байна. Гэсэн ч зах зээлийн эдийн засгийн хөгжлийг илэрхийлэгч эрх чөлөөт байдлын энэ үзүүлэлт монголын хувьд мэдэгдэхүйц сайжирч байна гэж үзэхэд өнөөдөр эрт байна. Учир нь бүрэн эрх чөлөөт оноо 100 юм.



Д. Монгол Улсын нийгмийн хөгжлийн тодорхой асуудлын чиг хандлага, тулгарч буй сорилт, бэрхшээлийг системтэй харьцуулж хоёр жил тутам НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс Монгол Улсын Засгийн газартай хамтран гаргадаг “Монголын хүний хөгжлийн Илтгэл”-д улс төрийн хөгжил, ардчиллын биелэлтэй холбоотой асуудлыг тусгадаг билээ. 2011 оны Хүний хөгжлийн индекс Илтгэлд: “Монгол Улсын хувьд Мянганы хөгжлийн дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэн хүрэх томоохон алхмууд нь ардчилал, ардчилсан засаглалын төлөвшүүлэх, ил тод нээлттэй иргэдийн оролцоот шударга төрийг хөгжүүлэхтэй шууд уялдах ёстой. Энэ ч утгаараа иргэд нь үгээ хэлдэг, төлөвлөлт нь олон нийтийн бодит идэвхтэй оролцоо, хэрэгцээнд тулгуурласан хүмүүнлэг, иргэний ардчилсан хөгжлийн зарчмыг баримталсан уян хатан байх нь бидний ямагт анхаарч байх үндсэн шаардлага билээ<sup>3</sup>” гэжээ.

<sup>3</sup> Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт, үндэсний дөрөв дэх илтгэл (Монгол Улс) УБ., 2011 он, 145 дах тал.

Е. Дотоодын эрдэм шинжилгээний байгууллагын зарим нэг судалгааны дүнгийн тойм:

- Монгол Улсын сонгож авсан ардчилсан хөгжлийн чиг шугамыг иргэд тууштай дэмжиж байгаа дүр зураг бараг бүх судалгаанаас гарсан байдаг. Энэ нь монголын ард түмний сэтгэл зүйд ардчиллыг өргөн хүрээнд нягтруулан хөгжүүлэх хүсэл эрмэлзэл баттай бий болсныг харуулж байна. Тухайлбал, 1989-1990 онд Монгол Улс ардчилалд шилжсэнийг хүн амын дийлэнх нь зөв (80 орчим %) үзсэн хэвээр байна<sup>4</sup>.
- Ардчиллын хөгжлийн суурь баталгаа нь иргэдийн олонхийн итгэл үнэмшил болсон ардчилсан үнэлэмж, үнэт зүйл гэж үздэг. Ардчилсан институциуд нь энэхүү итгэл үнэмшлийг илэрхийлэгч, тээгч тогтолцоо нь болно. Монгол Улсын үндсэн хуулийн дагуу ардчиллын институци бүгд бүрэлдэн тогтсон юм. Харин ардчилсан үнэлэмжийн хөгжил, төлөвшил дэх өөрчлөлт мэдэгдэхүйц болсон гэж үзэх эрт байна. Учир нь ардчиллын үзэл санаа бодит байдалд хэрэгжсэн гэж зөвхөн 50-60 хувь үзэж байна<sup>5</sup>. Эндээс, хоёр хандлагыг таамаглалын хэмжээнд дэвшүүлж болно. Нэгд, ардчиллын үзэл санааны хэрэгжилт иргэдийн хүсэн хүлээж буй тэрхүү хэмжээнд хүрэхгүй байна. Энэ байдал удаан хадгалагдах аваас ардчилалд шилжсэнийг зүйтэй гэж үзэх ерөнхий хандлага буурах магадлалтай байх болно. Хоёрт, ардчиллын тэрхүү бодит биелэлийн цаана олон нийт тодорхой юуг хүсэн хүлээж байгаа талаарх ойлголт нь мөн бүдэг байна. Тухайлбал, либерал ардчиллын утга санааны талаар монголчуудын таван хүний дөрөв нь доогуур ба ерөөсөө энэ талаар ойлголтгүй байна. Ийм учраас монголчуудын гуравны хоёр нь авторитар дэглэмийн шинжүүдийг ямар нэгэн байдлаар дэмжихэд бэлэн байгаа нь судалгаанаас харагддаг. Энэ нь монголчуудын улс төрийн гэгээрлийн асуудал онцгой анхаарах түвшинд хүрсэнийг харуулж байна.
- Улс орны хөгжлийн тулгамдсан чухал асуудлуудыг тодруулсан байдлаас үзэхэд ажилгүйдэл, ядуурал, авлига, хариуцлагагүй байдал, хүнд суртал, шударга бус явдал гэсэн үзүүлэлтүүд иргэдийн санаа бодлыг хамгийн их зовоож буй асуудал гэж ихэнх судалгаанд гардаг. Үүнийг ардчилалд нөлөөлөх хүчин зүйлсийнх нь талаас харвал ардчилсан үйл явцыг бодитой, үр нөлөөтэй хэрэгжүүлэх эдийн засаг, нийгэм, ажил хэргийн болон зохион байгуулалтын суурь хүчин зүйлүүд хангалтгүй байгаагийн илэрхийлэл гэж үзэхээс өөр аргагүй

<sup>4</sup> "Монголын хүний хөгжлийн илтгэл. 2010. Монгол Улсын засгийн газар. НҮБХХ.

<sup>5</sup> How East Asians View Democracy: Regime Performance and Authoritarian Detachment. Yun-han Chu. Taipei, 2003

байна.

- Хуулийн эрх зүйн талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг дутмаг, иргэд хуулиар хамгаалуулж амьдрах, ажил амьдралдаа хууль хэрэглэх дадал зуршилд удаан суралцаж байгааг манайд хийгдсэн судалгааны мэдээллүүд харуулж байна. Төрийн зүгээс үзүүлэх хууль зүйн мэдээллийн үйлчилгээ сул, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудын ажлын цар хүрээ хязгаарлагдмал, сонирхлын бүлгүүд хийгээд иргэдийн зүгээс гаргаж буй идэвх санаачлага муу байгаатай үүнийг холбож үзэх үндэстэй.

## Дүгнэлт

Сүүлийн үед ардчилалд нэлээдгүй их төвөг бэрхшээл учирч байгаа ба энэ нь ардчилал мухардалд орох, эргэж дарангуйллын ямар нэгэн хэлбэр тогтох нөхцөлийг бий болгох магадлалтай юм. Ялангуяа, дараах нөхцөл байдлын улмаас ардчилалд аюул нүүрлэж болохыг түүхэн туршлага харуулсаар байгаад бид сургамж авч дор бүрдээ дүгнэлт хийн энэхүү алдаа гажуудлыг давтахгүй байхыг хичээх хэрэгтэй болов уу. Үүнд:

- Зайлшгүй шийдвэрлэгдэх ёстой асуудал шийдвэрлэгдэхгүй хуримтлагдах
- Ардчилсан институциуд ардчилсан ёсоор ажиллаж чадахгүй гацаанд орох
- Гүйцэтгэх эрх мэдэл өсөн нэмэгдэж, юм бүхэнд оролцож зохицуулах гэдэг хандлагатай болох
- Өргөн олон түмэн улс төрийн бодлого болон улс төрчдөд итгэхээ болих, тэдгээрт дургүйцэх зэрэг болно.

Ийм л дэвсгэр дээр түшиглэж ардчиллаас эргэж буцах, авторитар, тоталитар дэглэм дахин сэргэж, сэхэх бололцоо байнга оршиж байдгийг батжиж бэхжээгүй шинэ залуу ардчилал бүхий улс орнууд мартаж болохгүй юм.

Ардчиллыг алдах эсхүл батжуулан бэхжүүлэх эсэх нь зөвхөн ард иргэдээс өөрсдөөс нь шалтгаалахаас бус өөр хэнээс ч үл хамаарах учраас иргэдийн итгэл найдвар, хамтын хүчин чармайлтаар л ардчиллын өмнө тулгарч буй аливаа аюул, саад бэрхшээлийг даван туулснаар ачийг нь хүртэх ёстой. Ардчилсан нийгмийн мөн чанар чухамхүү үүнд л оршдог учраас ийм нийгэмд амьдарч буй хүн бүхэнд энэхүү бичигдээгүй хууль хүчин төгөлдөр үйлчилдэг юм.

Т. Жефферсон “Ард түмнээс өөр, нийгмийн эцсийн дээд эрх мэдлийг найдвартай хамгаалж чадах, хэнийг ч би мэдэхгүй. Хэрэв ард түмэн эрхээ бүрэн хэмжээгээр хэрэгжүүлж чадах түвшинд боловсроогүй гэж үзэж байвал үүнийг ард түмнээс эрхийг нь булаах замаар биш, харин тэднийг гэгээрүүлэн эрхийг нь мэдүүлэх замаар л эмчлэх ёстой” гэж хэлсэн байдаг. Тийм ч учраас ардчилал бүхий газар иргэн төр хоёр хамтран ажилладаг бөгөөд нэг талаас, төр засгийн зүгээс иргэдийг улс төрийн амьдрал, төрийн үйл хэргийг удирдахад өргөнөөр оролцох бүхий л бололцоог хангаж өгөх үүрэгтэй, нөгөө талаас, тийм орчин нөхцөлийг иргэд төрөөс шаардах эрхтэй байдаг.

Ер нь соён гэгээрсэн ард түмэн хэзээ ямагт хүчтэй байдаг, тийм ард түмнийг удирдахад амархан, харин дарлахад хэцүү гэлцдэг шүү дээ. Хэрвээ төр засаг ард түмнээ гэгээрүүлэхгүй, мэдээллээр хангахгүй, хаалттай харанхуй байлгахыг хүсч байгаа бол тэднийг “дээр нь юу ч бичиж болох цагаан цаас” мэт болгож дарангуйлах л гэсэн хэрэг болно.

## **Тэгвэл ард иргэд ардчиллаа алдахгүй, батжуулан бэхжүүлэхийн тулд яах вэ?**

- Иргэн бүр юуны өмнө ардчиллын талаар зохих мэдлэгтэй, боловсролтой чадварлаг, хариуцлагатай байх. Үүний тулд иргэн хүн бусдын нэр төр, үзэл бодлыг нь хүндэтгэх, хуулинд захирагдах, нийгмийн үйл хэрэгт оролцох эрмэлзэлтэй байх, олонхийн зарчмыг баримталж, цөөнхийн эрхийг хүндэтгэх, шударга бус хууль дүрмийг хуулийн дагуу, тайван замаар өөрчлөх эрмэлзэлтэй байх ёстой.
- Нийгмийн амьдралд идэвхтэй оролцох чадвартай болохын тулд иргэн хүнд юу хэрэгтэй вэ? гэвэл бусадтай харилцан ярилцах, хамтран ажиллах, асуудлыг хуулийн дагуу зөвшилцөлд хүрэх зэргээр оролцооны чадварт суралцах шаардлагатай болно.
- Хүн төрөлхтний хүлээн зөвшөөрсөн үнэт зүйлс болох ардчилсан сонголт, эрхэм зорилгоосоо иргэн бүр хэзээ ч үл ухарч няцах итгэл үнэмшилтэй байх.
- Иргэн бүр өөрсдийн эрх, эрх чөлөөг эдлэхийн зэрэгцээ үүрэг хариуцлага хүлээхээ ухамсарлах
- Иргэн бүр улс төрд идэвхтэй оролцох, төр засгийн бодлого, шийдвэрийг шүүн хэлэлцэж, тодорхой асуудлаар зөвшилцөж, бие биендээ хүлээцтэй, тэвчээртэй хандах.
- Иргэн бүр өөрсдийгөө төлөөлж буй байгууллага болон төлөөлөгчид хяналт тавих, үйл ажиллагаа нь зөв зүйтэй явагдаж байвал итгэл үзүүлэх, буруу байвал шаардлага тавьж, нөлөө үзүүлэх.
- Иргэн бүр өөрийн чөлөөт амьдралын баталгаа болсон үндсэн хууль, бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөх, сахин биелүүлэх.
- Иргэд үзэл бодол, сонирхлоороо сайн дураараа эвлэлдэн нэгдэж, эвсэл холбоо, хөдөлгөөн байгуулан эрх ашиг, сонирхлоо илэрхийлэн хамгаалах.
- Иргэн бүр ардчилсан сонгуульдаа идэвхтэй оролцож, хүсэл зоригоо хэний ч нөлөөнд авталгүй бие даан илэрхийлж, өөрийн хүсч буй төр засгаа тогтоон байгуулах.
- Иргэн бүр нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, өөрийн орон нутгийн асуудлыг хамтран шийдвэрлэх, зохион байгуулах, хариуцаж сурах зэрэг шаардлага нь иргэдийн зүгээс ардчиллыг баталгаажуулах нөхцөл болон зүй ёсоор тулгарч байна.

Иргэн Та ийм л мэдлэг, чадвар, хариуцлага бүхий идэвхтэй оролцоогоор тэмцэж олсон ардчиллаа алдчихгүй, батжуулан бэхжүүлж чадах билээ.


## ШИНЭ СОНГОГЧ ТӨСӨЛ 2016




Н. Цэцэнбилэг



Д. Дандийдам



А. Хишигдалай



С. Зоригтбаатар








## ШИНЭ СОНГОГЧ ТӨСӨЛ 2016




Н. Цэцэнбилэг



Д. Дандийдам



А. Хишигдалай



С. Зоригтбаатар